

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019.01.04

Улаанбаатар хот

**НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР**

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (ТӨБЗГ) нь Ерөнхий сайдын 2016 оны 57 дугаар захирамжаар батлагдсан “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-т тусгагдсан дараах стратегийн зорилтыг хангах хүрээнд хууль тогтоомжоор тогтоож өгсөн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллав:

- Стратегийн зорилт 1: Төрийн өмчийн талаар хууль тогтоомж, бодлого, чиглэл, баримт бичгийн төсөл боловсруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн засаглалыг сайжруулах удирдлага, зохион байгуулалтаар хангах;
- Стратегийн зорилт 2: Төрийн өмчийн эзэмших, ашиглах, хамгаалахтай холбоотой бүртгэл, тооллого явуулах, төрийн өмчийн бүрэн бүтэн байдал, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн байдалд хяналт тавих;
- Стратегийн зорилт 3: Худалдан авах ажиллагааг төлөвлөн батлагдсан төсвийн хүрээнд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай байх зарчимд тулгуурлан зохион байгуулах, тайлагнах;
- Стратегийн зорилт 4: Захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, мэдээлэл, технологийн хөгжлийг хангах.

Тус агентлаг нь батлагдсан стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн дагуу зохион байгуулалтын бүтцийн 5 нэгж, 75 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулав:

Зохион байгуулалтын бүтцийн нэгж:


1. Захиргаа, хууль зүйн хэлтэс
2. Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс
3. Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс
4. Худалдан авах ажиллагааны хэлтэс
5. Мэдээлэл, технологийн алба.

2018 оны 12 дугаар сарын байдлаар тус байгууллагад нийт 74 албан хаагч ажиллаж байна. Хүүхэд асрах чөлөөтэй байгаа төрийн захиргааны 3, төрийн үйлчилгээний 2 албан хаагч, гадаадад магистрын сургалтад суралцаж байгаа төрийн захиргааны 1 албан хаагч байгаа бөгөөд тэдгээрийн оронд 6 албан хаагчийг түр томилон ажиллуулж байна.

1 дүгээр зураг



2 дугаар зураг



Нийт албан хаагчдын 43 нь эмэгтэй, 31 нь эрэгтэй.

Албан хаагчдын насны ангилал:

- 40-өөс дээш насны албан хаагч – 21 буюу 28.4%;
- 30-40 насны албан хаагч - 35 буюу 47.3%;
- 20-30 насны албан хаагч - 18 буюу 24.3% байна.

*Газрын үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах:* Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь байгууллагын үйл ажиллагааны эрхэм зорилго, стратегийн зорилтыг хангах хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль холбогдох бусад хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030”, “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл”, холбогдох үндэсний хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг уялдуулан хэрэгжүүлэхээр байгууллагын үйл ажиллагаа (гүйцэтгэлийн төлөвлөгөө)-ны 2018 оны төлөвлөгөөг Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу Ерөнхий сайдаар батлуулан хэрэгжүүлэв. Байгууллагын үйл ажиллагаа, батлагдсан төсвийн зарцуулалтын үр дүнг Төсвийн ерөнхийлөн захирагчийн өмнө газрын дарга хариуцахаар Ерөнхий сайдтай Үр дүнгийн гэрээ байгуулан ажилласан болно.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь стратегийн 4 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 10 хөтөлбөрт хамаарах 84 арга хэмжээг 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө (гүйцэтгэлийн төлөвлөгөө)-ндөө тусган хэрэгжүүлсэн. Хэрэгжилтийн дүнг 1 дүгээр хүснэгтээр харуулав. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд хэлтэс, албан хаагчдад төлөвлөгөөг [www.able.mn](http://www.able.mn) дотоод сүлжээгээр хүргүүлэн танилцуулж, хэлтэс, албан хаагчид жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн гэрээ нарийвчлан боловсруулж, батлуулсан.

1 дүгээр хүснэгт

ТӨБЗГ-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн дүн

Д/д	Хэрэгжилтийн явц (үнэлгээний хувь)	Заалтын тоо	
		2017	2018
1	<b>Нийт хэрэгжүүлэх арга хэмжээ</b>	<b>108</b>	<b>84</b>
2	Үүнээс: “Бүрэн хэрэгжсэн” – 100 %	77	73
3	“Хэрэгжих шатанд” – 70 %	22	10
4	“Хэрэгжилт хангалтгүй” – 30 %	5	0
5	“Хэрэгжээгүй” – 0 %	4	0
6	“Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”	0	1
7	<b>Хэрэгжилтийн дундаж хувь (үнэлгээ)</b>	<b>86.9</b>	<b>96.4</b>

Хэлтэс бүрийн сарын ажлын тайланд үндэслэн ТӨБЗГ-ын сарын ажлын тайланг нэгтгэн боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхийн зэрэгцээ, төрийн мэдээллийн цахим сүлжээнд заалт бүрээр оруулан Засгийн газрын хяналтад бүртгүүлсэн.

Мөн хэлтсүүдийн 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө хийж, хэрэгжүүлэх томоохон арга хэмжээ, ажлын мэдээллийг хэлтсүүдээс авч нэгтгэн газрын удирдлагад танилцуулж, ажлыг төлөвлөгдсөн хугацаанд гүйцэтгэх үүргийг нийт албан хаагчдад өгч, удирдлага, чиглэлээр ханган ажиллав.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөг 8 заалттайгаар баталж, хэрэгжилтийг 100 хувь хангасан. Тус төлөвлөгөөний хүрээнд ТӨБЗГ-ын албан хаагчдыг соён гэгээрүүлэх, шинэ мэдлэг, мэдээлэл олгох сургалтыг 32

удаа зохион байгуулж, иргэд, олон нийтээс ирсэн 224 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, ажлын байрны давхардлын судалгааг хийж, албан хаагчдын цаг ашиглалтыг сайржуулан, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, ажлын тайланг сар бүр ЗГХЭГ-т хүргүүлэн ажилласан.

*Бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах:* Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, бусад бодлого, хөтөлбөр болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн холбогдох заалтыг хяналтад авч хэрэгжүүлэн Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон бусад холбогдох дээд шатны байгууллагад тайлагнаж, байгууллагын цахим хуудас [www.pcsp.gov.mn](http://www.pcsp.gov.mn) –д байршуулан нээлттэй мэдээлж байна.

2018 онд тус агентлагт 4 төрлийн 70 бодлого, шийдвэрийн нийт 157 заалт (арга хэмжээ)-ыг хяналтад авч, хэрэгжилтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт болон бусад яам, байгууллагад хүргүүлэн тайлагнасан байна. Эдгээр 157 заалтын хэрэгжилтийг 2018 оны жилийн эцсийн дүнгээр дунджаар 93.2 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хэрэгжүүлж байгаа бодлого, шийдвэрийн хяналтад авсан заалтын хэрэгжилтийн явцын дүнг 2 дугаар хүснэгтээр танилцуулав.

2 дугаар хүснэгт

Бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн дүн


Д/д	Бодлого, шийдвэрийн		Хэрэгжилтийг тооцсон заалт	Хэрэгжилтийн явц (хувь)	
	нэр төрөл	тоо			
1	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	2017 оны жилийн эцэс	1	18	88.8
		2018 оны жилийн эцэс	1	22	90.0
2	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл	2017 оны жилийн эцэс	1	2	85.0
		2018 оны жилийн эцэс	1	4	100.0
3	Үндэсний хөтөлбөр (Авлигатай тэмцэх ҮХ, Эдийн засгийг сэргээх хөтөлбөр)	2017 оны жилийн эцэс	2	17	70.0
		2018 оны жилийн эцэс	1	17	87.5
4	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр	2017 оны жилийн эцэс	72	104	86.1
		2018 оны жилийн эцэс	67	114	95.1

*Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаан:* Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын ээлжит хуралдааныг танхимд 18, санал авах хуудсаар 16, нийт 34 удаа бэлтгэл ажлыг ханган, Хуралдааны дэгийн дагуу зохион байгуулж, 741 асуудал хэлэлцүүлэн, 664 тогтоол, 26 тэмдэглэлийг албажуулсан. Тогтоолыг агуулгаар нь ангилан харуулбал:

1. Эрх зүйн акт-6,
2. Хуулийн этгээдийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц -19,
3. Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин-136,
4. Хуулийн этгээдийн удирдлагыг томилох, чөлөөлөх-12,
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн томилох, чөлөөлөх-27,
6. Хуулийн этгээдийн бусад асуудлаар-13,
7. Өмч, хувьчлал-8,
8. Хөрөнгийн шилжилт хөдөлгөөн-422,
9. Хяналт, шалгалт-21.

Мэдээллийн ил тод байдлыг хангаж олон нийтэд мэдээлэх зорилгоор газрын тогтоол, тэмдэглэлийг ТӨБЗГ-ын [www.pcsp.gov.mn](http://www.pcsp.gov.mn) цахим хуудсанд төрөлжүүлэн байршуулж, эд хөрөнгө актлах, устгах, дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай 2018 оны тогтоол, тэмдэглэлийг сар бүр, 2017 оны 23 удаагийн хуралдаанаар шийдвэрлэгдсэн 215 тогтоолыг тус тус [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn)-д байршууллаа.

### 3 дугаар зураг



программыг 3 дугаар зурагт харуулав.

Газрын тогтоол, хуралдаанаас гарсан шийдвэр, түүний биелэлтийн цахим мэдээллийн программ боловсруулах, хөгжүүлэх асуудлыг шийдвэрлэсэн. Тус программыг [www.pcsp.gov.mn](http://www.pcsp.gov.mn) цахим хуудасны үндсэн цэс байхаар боловсруулан, албан хаагчдад танилцуулж, саналыг тусган хэрэглээнд нэвтрүүлсэн. Энэхүү ажлын хүрээнд ТӨБЗГ-ын 2018 оны 690 шийдвэрийг төрөл, дэд төрөл, хянах болон хариуцсан албан хаагчаар ангилан, шийдвэрийн скайнердсан файльтай тулгалт хийсэн. Тус

“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдааны дэг”-ийг баримтлан ажиллах тухай санамж боловсруулж дэд дарга, ЗХЗХ, БТУХ, ТӨБХХ, ХААХ-ийн дарга, ахлах мэргэжилтэн нарт танилцуулж, гарын үсэг зуруулан нийт албан хаагчдад Able.mn дотоод сүлжээгээр хүргэсэн. Газрын хуралдааны гишүүдийн ирцийг сар бүр гарган, 7.5 сая төгрөгийн урамшууллыг олгосон.

2017 онд газрын хуралдаан нийт 28 удаа хуралдаж 735 (давхардсан тоогоор) асуудал хэлэлцэн 684 тогтоол, 24 тэмдэглэл гарсныг асуудал танилцуулсан хэлтэс бүрээр ангилж, БТУХ, ТӨБХХ-ээр биелэлтийг гаргуулан нэгтгэж, биелэлтийг 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн Газрын хуралдаанд танилцуулсан. 2017 оны газрын тогтоолын хэрэгжилт 95.3%, тэмдэглэлийн хэрэгжилт 66.2%-ийн биелэлттэй байсан бөгөөд 448 (65%) тогтоол, 14 (42%) тэмдэглэл хяналтаас хасч, 236 (35%) тогтоол, 14 (58%) тэмдэглэлийн биелэлтийг хяналтад хэвээр үлдээсэн.

Мөн 2017 оны ТӨБЗГ-ын тогтоол, шийдвэрийн биелэлтийг АТГ-аас томилогдсон “Олон нийтийн зөвлөл”-д хүргүүлж танилцах боломжийг олгосон. Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас шалгалт хийсэн аудиторын шаардлагын дагуу газрын 2017 оны тогтоолын жагсаалт, тогтоолыг, Авлигатай тэмцэх газраас ажилласан авлигын эсрэг зөвлөмжийн биелэлтийг шалгах багт шаардлагатай тогтоолыг тухай бүр гарган өгч хяналт, шалгалт хийх боломжийг бүрдүүлсэн.

*Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Даргын зөвлөлийн хурал:* Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Даргын зөвлөлийн хурлыг 2018 оны эхний хагас жилд 4 удаа хуралдуулж, дараах асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлэсэн:

1. 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2017 оны хэрэгжилтийн тайлангийн тухай, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайлангийн тухай,

2. 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2017 оны хэрэгжилтийн тайлангийн тухай,

3. 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн эхний хагас жилийн хэрэгжилтийн тайлангийн тухай, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2018 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайлангийн тухай,

4. 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Үйл ажиллагааны нэмэлт орлого зарцуулах тухай” А-294 дугаар тушаалаар олгогдсон эрхийн зарцуулалтын тухай.

2018 онд газрын шуурхай хурлыг 11 удаа зохион байгуулж, газрын сар бүрийн хийсэн ажлын мэдээллийг албан хаагчдад танилцуулан, ажил эрчимжүүлэх талаар удирдлагаас чиглэл өгч, ажиллав. Мөн Бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар Даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр өгсөн үүрэг чиглэлийг хэлтэс, албан хаагчдад тухай бүр [www.able.mn](http://www.able.mn) дотоод сүлжээгээр дамжуулан хүргэж, хэрэгжилтийг зохион байгуулан ажилласан.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дотоод аудитын 2018 оны төлөвлөгөөнд нийт 9 ажил тусган боловсруулж, газрын даргын 2018 оны А/14 дүгээр тушаалаар баталсан. Төлөвлөгөөнд төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Шилэн дансны хуулийн хэрэгжилт, ТУЗ-д өгсөн удирдамжийн биелэлт, ТӨБЗГ-ын төсвийн зарцуулалт, архив, албан хэрэг хөтлөлт, худалдан авах ажиллагаа, түрээсийн гэрээ, дуудлага худалдаа, үндсэн хөрөнгө актлах шийдвэр, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан гэрээний хэрэгжилтэд аудит хийхээр тусган, төлөвлөгөөг байгууллагын дотоод сүлжээ [www.able.mn](http://www.able.mn) –д байршуулан нийт албан хаагчид мэдээлсэн.

Тус төлөвлөгөөнд тусгагдсан төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Шилэн дансны хуулийн хэрэгжилт, ТУЗ-д өгсөн удирдамжийн биелэлт, дуудлага худалдаа, үндсэн хөрөнгө актлах шийдвэрийн биелэлтэд аудит хийсэн боловч дүгнэлт, зөвлөмж эцэслэн гараагүй. 2018 онд “Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хийсэн гэрээ”-ний хэрэгжилтэд 12 дугаар сард аудит хийсэн бөгөөд тус аудитын дүгнэлт, зөвлөмжийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Даргын зөвлөлд танилцуулахаар бэлтгэж байна.

#### 1.1. Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар

1.1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг боловсруулж, батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Уг хуулийн төслийг батлуулах зайлшгүй шаардлага болон хуулийн төсөлтэй холбоотой нийт 24 албан бичгийг ЗГХЭГ болон дээд шатны байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөл ажиллаж, хуулийн төсөлд тодорхой асуудлаар санал тусгасан. Хуулийн төслийн үзэл баримтлал батлагдан УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэх асуудал дэмжигдэж, 2018 оны намрын чуулганаар хэлэлцэх хууль тогтоомжийн жагсаалтад тусгагдсан боловч хэлэлцэх асуудал хойшлогдсон.

1.1.2. Төрийн болон орон нутгийн өмчийн талаарх хууль тогтоомж, бодлого, шийдвэр, баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулах ажлын хүрээнд дараах төслийг боловсруулан Улсын Их Хурал, Засгийн газар, бусад дээд шатны холбогдох байгууллагад хүргүүлсэн:

- “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаарх Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын протокол,

хэлэлцээрийг соёрхон батлах хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл;

- Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас санаачилсан Казиногийн тухай хуулийн төсөлд тусгах санал;
- Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн төсөлд тусгах санал;
- Төрийн албан хаагчийн хариуцлагын тухай хуулийн төсөлд тусгах санал;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгах санал;
- Улсын Их Хурлын “Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” тогтоолын төсөл;
- “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл”-ийн төсөл;
- “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын шинэчилсэн найруулгын төсөл;
- Улсын Их Хурлын 2017 оны 23 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах санал.

“Цахим тендер зохион байгуулах журам”, “Тендерийн жишиг баримт бичиг”-т холбогдох өөрчлөлт оруулах санал боловсруулж, Сангийн яаманд хүргүүлэв.

ШӨХТГ-аас зохион байгуулсан “Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн хэлэлцүүлэгт ТӨБЗГ-ын газрын төлөөлөл оролцож, худалдан авах ажиллагаатай холбоотой санал хэлэлцүүлэв.

Дампуурлын тухай хуулийн төсөл, Шилэн дансны тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ТӨБЗГ-ын төлөөлөл тус тус ажилласан.

“Паспортжуулалтын зөвлөлийн дүрэм”-ийн төслийг нийт албан хаагчдад танилцуулан, саналыг нэгтгэж, Нийслэлийн Засаг даргад, “Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэх журам”-ын төсөлд тусгах санал боловсруулж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт тус тус хүргүүлэв.

“Онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн болон албаны нууцыг хамгаалах төлөвлөгөө”-ний төслийг ТЕГ-т танилцуулж, ТӨБЗГ-ын даргын А/02 дугаар тушаалаар, Нууц баримт бичгийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын төсөлд Тагнуулын байгууллагаас санал авч, ТӨБЗГ-ын даргын А/277 дугаар тушаалаар тус тус батлан мөрдүүлэв.

Монгол бөхийн өргөөний асуудалтай холбогдуулан “Бүрэн эрхт төлөөлөгч” томилох талаарх хууль, эрх зүйн зохицуулалтыг судалж, үүссэн нөхцөл, зарим асуудлын талаар ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, ЗГХЭГ-т зохих тайлбар, санал хүргүүлэв. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2018 оны 276 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

1.1.3. Улсын Их Хурлын “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын төслийг холбогдох яам болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын саналыг авсны үндсэн дээр боловсруулж, Ерөнхий сайд, Засгийн газарт 03 дугаар сарын 21-нд хүргүүлсэн. Уг төсөлд нийт 18 хуулийн этгээдийг бүрэн хувьчлах, 19 хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг бууруулах, нийт 37 хуулийн этгээдийг хувьчлах талаар тусгагдсан. Дээрх тогтоолын төсөл бүхий саналыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, 23 хуулийн этгээдийг бүрэн хувьчлах, 4 хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг бууруулах, нийт 27 хуулийн этгээдийг хувьчлах саналыг 2018 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн ЗГ-1/112 дугаар албан бичгээр Улсын Их Хуралд өргөн барьсан. Улсын Их Хурал тус саналыг хэлэлцээд, Эдийн засгийн байнгын хороонд дэд ажлын хэсэг байгуулан зарим судалгаа тооцоог хийх чиглэл өгсөн



1.1.4. Төрийн өмчөөс хувьчилж үл болох аж ахуйн нэгж болон эд хөрөнгийн талаарх танилцуулга, саналын төслийг төрийн байгууллага, дэд бүтцийн салбар, хүнс, хөдөө аж ахуйн салбар, байгаль орчны салбар, боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбар, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбар, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд ногдох хэсэг гэсэн ангиллаар гарган, УИХ-ын 1999 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчөөс хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалт”, уг жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах талаар салбарын 12 яамнаас ирүүлсэн болон ТӨБЗГ-ын саналыг харьцуулсан судалгааг нэгтгэн дүгнэв.

УИХ-ын “Төрийн өмчөөс хувьчилж үл болох аж ахуйн нэгж болон эд хөрөнгийн жагсаалт батлах тухай” тогтоолын төсөл боловсруулж, холбогдох материалын хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн боловч Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2018 оны ХЭГ/281 дугаар албан бичгээр уг тогтоолын төслийг буцаасан.

1.1.5. Төрийн болон орон нутгийн өмчид хяналт тавьж, өмчийн эзэмшилт, ашиглалтыг сайжруулах зорилгоор ТӨБЗГ-ын 2018 оны 86 дугаар тогтоолоор “Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам”-ыг баталж, төрийн өмчит нийт байгууллагад мөрдүүлэх арга хэмжээ авав. “Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам”-ыг байгууллагын цахим хуудас <http://pcsp.gov.mn>-нд байршуулж, мэдээллийн ил тод байдлыг хангав.

1.1.6. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэх 741 асуудлын төсөл, 664 тогтоол, 26 тэмдэглэл, 411 тушаал, 3951 (ТӨБХХ, МТА-аас бусад хэлтэс орсон) албан бичиг, тендерийн баримт бичиг, урилга, мэдэгдэл, тайлан зэрэг баримт материалын төслийн хууль зүйн үндэслэлийг хянаж, хуульд нийцүүлэн боловсруулж, албажуулахад дэмжлэг үзүүлсэн.

1.1.7. ТӨБЗГ-ын албан хаагчдын дунд “Хууль тогтоомж сурталчлах сарын аян”-ыг 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдрийн хооронд төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, төрийн өмчийн бүртгэл, хяналт, төрийн өмчийн удирдлага, менежмент, төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагаанд тус тус дагаж мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд 9 удаагийн сургалт сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 387 албан хаагчийг хамруулсан. Сэдэв тус бүрийн хүрээнд “АХА” тэмцээнийг 4 удаа зохион байгуулж, шилдэг оролцогчдын дунд “Зуун мянгын уналт” хөгжөөнт тоглоом зохион байгуулсан. “Хууль тогтоомж сурталчлах сарын аян”-ныг 4 дүгээр зурагт харуулав.

4 дүгээр зураг



1.1.8. 2018 онд хамтран ажиллах 7, худалдан авах 7, аж ахуйн 3, төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагатай 31, бусад төрлөөр 3, нийт 52 гэрээний хууль, эрх зүйн үндэслэлийг хянаж, дугаар олгон, бүртгэлд хамруулсан. Мөн Худалдан авах ажиллагааны хэлтсийн зохион байгуулсан тендерт шалгарсан 57 хуулийн этгээдийн гэрээ, зарим төрлийн нэршлийн эмийг худалдах ерөнхий гэрээ байгуулсан 39 хуулийн этгээдийн гэрээг тус хэлтсээс татан авч скайнердан цахим архив болгож, эх хувийг Худалдан авах ажиллагааны хэлтсийн хариуцсан албан хаагчдад хүлээлгэн өгсөн.

## 1.2. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага, менежментийн чиглэлээр

1.2.1. Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 76 хуулийн этгээдийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот

түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг ТӨБЗГ-ын даргын 2017 оны А/181 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргаж, ТӨБЗГ-ын хуралдааны тогтоолоор тус тус баталсан. Тайлант хугацаанд зарим хуулийн этгээдийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тодотголыг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авсан.

1.2.2. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, үйлдвэрийн газрын захиралтай байгуулсан контрактын биелэлт, 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх үүрэг бүхий ажлын хэсгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын тушаалаар байгуулан ажиллуулав. Ажлын хэсэг ТӨБЗГ-ын 2017 оны 90 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын дагуу захиралтай байгуулсан контракт болон хуулийн этгээдийн 2017 оны зорилтот түвшинг дүгнэн газрын хуралдаанд танилцуулав. ТӨБЗГ-ын хуралдаанаас нийт 53 захирлын ажлыг “Сайн”, 10 захирлын ажлыг “Хангалттай” гэж дүгнэн 59 захирлын контрактыг 1 жилээр, 5 захирлын контрактыг 6 сараар шинэчлэн байгуулах шийдвэр гаргасан. 2018 оны сүүлийн хагас жилд “Булган АЗЗА” ТӨХК, “Орхон АЗЗА” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлыг чөлөөлж, шинээр томилсон. Мөн 6 сараар гэрээг байгуулсан гүйцэтгэх захирлуудын гэрээг дахин 6 сараар сунган ажиллуулав.

1.2.3. Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанд “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай” асуудлыг хэлэлцүүлсний дүнд Засгийн газрын 08 дугаар тогтоолоор авах арга хэмжээг шийдвэрлэсэн. Засгийн газрын энэхүү шийдвэрээр Улсын Их Хурлын “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын төслийг боловсруулахад баримтлах зарчим, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн үр ашгийг дээшлүүлэх талаар авах арга хэмжээний талаар тодорхой үүрэг даалгавар өгсөн.

Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, төрийн өмчит хуулийн этгээдийн үр ашгийг сайжруулах зорилгоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А-1/350 дугаар, 8 дугаар сарын 24-ний өдрийн А-2/3379 дүгээр албан бичгээр 2 удаа албан даалгавар, чиглэл өгөв. Засгийн газрын 2018 оны 08 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах талаар албан даалгаврыг нийт төрийн өмчит 73 хуулийн этгээдэд хүргүүлсэн. 69 хуулийн этгээдийн ирүүлсэн тайлан мэдээг нэгтгэн, хэрэгжилт, үр дүнг тооцон дүгнэлт хийв.

1.2.4. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагаа, засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргана” гэсэн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 9 хуулийн этгээдийн менежментийг сайжруулах, зардлыг бууруулах, үйл ажиллагааны давхардлыг арилгах, ашигт ажиллагааг сайжруулах арга хэмжээг боловсруулан Засгийн газарт санал хүргүүлсэн. Үүний үр дүнд, Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор алдагдалтай ажиллаж байсан болон үйл ажиллагаа нь зогссон “Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК, “Аж үйлдвэрийн цогцолбор” ТӨХК, “Монгол тамга” ТӨҮГ, “Монгол тариалан” ТӨҮГ, “Монгол мах” ТӨҮГ-ыг татан буулгасан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын тушаалаар Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Хүнс,



хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас тус тус төлөөлөл оролцуулан татан буулгах 4 комиссыг байгуулан ажиллуулав.

Засгийн газрын 2018 оны 288 дугаар тогтоолоор “Биокомбинат” ТӨҮГ, “Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори” ТӨҮГ, “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” ТӨҮГ-ыг татан буулгаж, ХХААХҮЯ-ны харьяанд улсын төсөвт үйлдвэрийн газар болгон шинээр байгуулсан.

“Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит үйлдвэрийн газрыг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөн байгуулах тухай Засгийн газрын 2018 оны 328 дугаар тогтоол гаргуулав. Компанийн дүрмийн төслийг боловсруулан Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргад санал авахаар хүргүүлсэн.

1.2.5. Тайлант хугацаанд нийт 53 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд 182 удирдамж өгч, удирдамжийн биелэлтийг 3-5 хоногт ирүүлэх үүргийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад өгч, биелэлтийг авч ажилласан. Тайлант хугацаанд компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг ТӨБЗГ-ын 12 удаагийн хурлаар хэлэлцүүлж, нийт 22 тогтоол, 1 тэмдэглэлийг тус тус батлуулан, давхардсан тоогоор нийт 119 ТУЗ-ийн 159 гишүүнийг чөлөөлж, 346 гишүүнийг томилсон байна. 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар төрийн өмчит 51 компанид 39 Төлөөлөн удирдах зөвлөл ажиллаж, 343 төрийн албан хаагч төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж байна.

### 1.3. Төрийн өмчийн бүртгэл, хяналтын чиглэлээр

1.3.1. Засгийн газрын 2015 оны “Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 184 дүгээр тогтоолын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, уг тогтоолыг шинэчлэх асуудлаар саналын төсөл боловсруулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны А-1/156 дугаар албан бичгээр Засгийн газарт хүргүүлсэн. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас өгсөн чиглэлийн дагуу төрийн өмчит хуулийн этгээдийн автомашины тоо, төрлийг шинэчлэн тогтоох чиглэлээр тээврийн хэрэгслийн нэгтгэлийн судалгааг салбар бүрээр гарган тоо төрөл, норм норматив, суудлын автомашины зардлын тооцоо, судалгааг хийж, нэгтгэн Засгийн газарт хүргүүлсэн. 2017 оны жилийн эцсийн балансын дүнгээр төрийн өмчит хуулийн этгээдэд бүртгэлтэй 6020 автомашины 2177 нь суудлын автомашин байна. Төрийн өмчит хуулийн этгээдүүд автомашины зардалд 2016 онд 51.0 тэрбум төгрөг, 2017 онд 46.0 тэрбум төгрөг зарцуулж, зардал 5.0 тэрбум төгрөгөөр хэмнэгджээ. 2017 онд суудлын автомашины зардалд 31.3 тэрбум төгрөгийг зарцуулсан нь нийт автомашины зардлын 68.0 хувийг эзэлж байгаа бөгөөд жолоочийн цалин, шатахуун, тослох материалын зардалд 27.1 тэрбум төгрөгийг зарцуулсан нь суудлын автомашины зардлын 86.6 хувийг эзэлж байна. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, шийдвэрлэх арга хэмжээ авах шаардлагатай байгаа.

1.3.2. Нууцын зэрэглэлтэй байгууллагын мэдээллээс бусад төрийн өмчит 1128, орон нутгийн өмчит 4958 хуулийн этгээдийн 2017 оны үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн мэдээ болон бусад судалгааны дүнг Үндэсний статистикийн хорооноос баталсан 17 төрлийн маягтын дагуу өмчийн мэдээ тайланг хянан хүлээн авч, санхүүгийн тайлангийн нэгтгэлийг 2018 оны А-5/739 тоот албан бичгээр Үндэсний статистикийн хороонд хүргүүлсэн.

1.3.3. “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-ийн дүүргэлтэд 2 удаагийн мониторинг хийж, мэдээллийн дүүргэлтийг сайжруулах асуудлаар 17 аймгийн Засаг даргад албан бичиг хүргүүлсэн. 2018 оны 01 дүгээр сарын 18-19 өдрүүдэд уг систем дэх газар, барилга, нийтийн эзэмшлийн байр, талбай, тээврийн

хэрэгсэл, дуусаагүй барилга, үнэт зүйлс, худаг, зам, гүүрийн мэдээллийн дүүргэлт, санхүүгийн тайлан зэрэгт хяналт тавьж, мониторинг хийсэн. 2018 оны 3 дугаар сарын 12-18-ны өдрүүдэд 21 аймаг дахь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мэдээллийн систем дэх санхүүгийн тайлангийн тулган баталгаажуулалтыг зохион байгуулах замаар мониторингийн ажлын чанар, үр нөлөөг нэмэгдүүлсэн. Үүний үр дүнд мэдээллийн баазын дүүргэлтийг сайжруулав.

1.3.4. 2018 онд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 33 хуулийн этгээдийн 2016-2017 оны үйлдвэрлэл, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийхээр төлөвлөсөн. Удирдлагын шийдвэрээр 3 хуулийн этгээдийн шалгалтыг хойшлуулсан. 2018 онд хийсэн хяналт шалгалт:

- төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 32 хуулийн этгээдийн 2016-2017 оны үйлдвэрлэл, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд удирдамжийн дагуу баримтын шалгалт;
- төлөвлөгөөнд тусгагдаагүй боловч иргэд, байгууллагын өргөдөл, гомдол, мэдээлэл, хүсэлтийн мөрөөр 4 хуулийн этгээдийн үйл ажиллагаанд;
- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд төрийн өмчит 8 их дээд сургуулийн төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд.

2017 онд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 33 хуулийн этгээдийн үйлдвэрлэл, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийж, нийт 74.8 тэрбум төгрөгийн зөрчил дутагдал илрүүлсэн. Энэхүү зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээг авч ажилласан бөгөөд үүрэг даалгаврын хэрэгжилтийн явцад мониторинг хийж, хяналт тавин ажиллав. Тайлант хугацаанд нийт 12 хуулийн этгээдэд мониторингийн хяналт хийсэн.

1.3.5. Засгийн газрын 2018 оны 8 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өр, авлагыг бууруулах чиглэлээр зөвлөмж боловсруулан хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах зохион байгуулалтын арга хэмжээ авав. Тэдгээрийн урт болон богино хугацаатай өр, авлагын судалгаа хийх зорилгоор 3 төрлийн хүснэгтийг боловсруулан төрийн өмчит 30 хуулийн этгээдэд хүргүүлэн судалгаа авч байна. 2016-2018 оны шалгалтад хамрагдсан төрийн өмчит 28 хуулийн этгээдийн өр, авлагын судалгаа, тэдгээрт хийсэн дүгнэлт шинжилгээний дүнг ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулахаар бэлтгэж байна.

1.3.6 Монгол Улс дахь Оросын Холбооны Улсын үл хөдлөх хөрөнгийн маргаантай асуудалтай холбоотой шийдвэрлэх асуудлын төслийг бэлтгэж, Монгол Улс, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын Комиссын хуралдаанд газрын дарга болон холбогдох албан хаагч оролцсон. Уг хуралдааны үеэр Оросын Холбооны Улсын Ажлын хэсэг болон холбогдох байгууллагын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, хэлэлцээр хийв. Монгол Улс, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгах саналыг боловсруулан Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн.

Ерөнхий сайдын захирамжаар байгуулсан ажлын хэсгийн ажлыг зохион байгуулах хүрээнд төрийн байгууллага болон иргэдээс ирүүлсэн маргаантай асуудалтай холбоотой албан бичигт хариу өгөх, шаардлагатай судалгаа, танилцуулгыг бэлтгэж хүргүүлэх ажлыг гүйцэтгэв. Мөн ТӨБЗГ-ын даргын 2018 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/171 дүгээр тушаалаар ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийн маргаантай асуудлыг судлах, санал боловсруулах, нэмэлт судалгаа, тооцоо хийх, хөрөнгийн байдалтай газар дээр нь

танилцах, дүгнэлт гаргах үүрэг бүхий дэд ажлын хэсгийг байгуулж, Ерөнхий сайдын байгуулсан ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэв. Энэ хүрээнд Монгол Улс дахь ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийн маргаантай асуудлыг зохицуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн гүйцэтгэсэн ажлын товч танилцуулгыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатарт 2018 оны А-1/3889 тоот албан бичгээр хүргүүлсэн.

#### 1.4. Худалдан авах ажиллагааны чиглэлээр

1.4.1. 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 174.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий нийт 133 (эрх шилжиж ирсэн 5 төсөл, арга хэмжээг оруулсан) төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ТӨБЗГ-т зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороог байгуулж, худалдан авах ажиллагааны талаарх хууль тогтоомжийн хүрээнд тендер шалгаруулалтыг зохион байгуулж ажиллав. Худалдан авах ажиллагааг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг байгууллагын цахим хуудас <http://pcsp.gov.mn>, төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <https://tender.gov.mn> -д тухай бүр байршуулан олон нийтэд мэдээлж ажиллав.

Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагатай хамтран ажиллах хүрээнд эдгээр байгууллагын зөвлөхүүд худалдан авах ажиллагааны мэргэжилтнүүдийн чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж ажилласан. ТӨБЗГ нь эдгээр байгууллагаас санхүүжүүлэн хэрэгжих дор дурдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх Засгийн газрын Ухаалаг засаг төслийн хүрээнд 1.08 сая ам. долларын төсөвт өртөг бүхий “Иргэдийн санал, хүсэлтийн мэдээлэлд бизнес анализ хийх олон улсын зөвлөх сонгох”, “Төрийн энтерпрайз архитектурын зөвлөх үйлчилгээ” төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгаа бөгөөд эдгээр 2 төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээ хийж байна.

“Мэргэжлийн хяналтын хорио цээрийн барилга байгууламжийн эх загвар зураг болон ажлын зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажилд хяналт тавих” L3313-МОН төсөл, арга хэмжээний тендерийг дахин зарласан.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр боловсролын салбарт хэрэгжих “Баруун бүсийн сургуулийн бага ангийн сурагчдын дотуур байрны нөхцөлийг сайжруулах” төслийн хүрээнд 886.1 мянган ам.долларын төсөвт өртөг бүхий 1 төсөл, арга хэмжээний 4 багц ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан.

1.4.2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2018 онд хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны тендерийн урилга, зар нийтлүүлэх өдөр тутмын сонинг сонгон шалгаруулах дотоодын нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулав. Тендерийн нээлтийг 2018 оны 1 дүгээр сарын 09-ний өдөр хийхэд Өдрийн сонин, Өнөөдөр, Засгийн газрын мэдээ, Үндэсний шуудан, Зууны мэдээ сонин тус тус тендер ирүүлсэн. Өдөр тутмын 3 хүртэлх сонинг сонгон шалгаруулах шаардлагын дагуу үнэгээний хороо үнэлгээ хийж, Өнөөдөр, Өдрийн сонин, Зууны мэдээ сонинтой 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдөр гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

1.4.3. 2018 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт зохион байгуулах худалдан авах ажиллагааны жагсаалтад дотоодод үйлдвэрлэсэн, чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн худалдан авах боломж бүхий төсөл, арга хэмжээ тусгагдаагүй. Тухайлбал, эмнэлгийн тоног төхөөрөмжийн 10 худалдан авах ажиллагаа байсан хэдий ч захиалагчаас ирүүлсэн техникийн тодорхойлолт, барааны жагсаалтад

дотоодод үйлдвэрлэсэн, чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн байж болох талаар шаардлага тавиагүй байсан.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2018 онд зарласан нийт 133 тендер шалгаруулалтыг зохион байгуулахдаа дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, дэмжих зорилгоор үндэсний үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн, чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг барилга угсралтын ажилд ашиглах тохиолдолд бараа материал болон ажиллах хүчний хувьд дотоодын давуу эрх тооцохоор тендерийн баримт бичигт тусгасан. 2018 онд гэрээ байгуулсан 121 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад хүсэлт ирүүлсэн 31 компанид дотоодын давуу эрх тооцож олгосон байна.

1.4.4. Үнэлгээний хорооны хуралдааны нөхцлийг сайжруулах хүрээнд техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийж, зөөврийн 8 компьютер, 6 принтер, 10 дуу хураагуур шинээр худалдан авсан. Энэхүү худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороо байгуулан ажиллуулж, нийлүүлэгчийг сонгон шалгаруулах замаар худалдан авсан. Тус худалдан авалт нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны төсвийн урсгал зардлаар худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэв.

1.4.5. 2018 онд худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалт зохион байгуулах эрх бүхий 8 төрийн бус байгууллагын улсын хэмжээнд зохион байгуулсан сургалтад хамрагдсан нийт 7144 албан хаагч, иргэдээс 411 удаа цахим хэлбэрээр шалгалт авснаас 4161 (58.2 %) -т нь худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшигчийн гэрчилгээ (А3)-г олгов.

2018 онд худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалтад хамрагдаж гэрчилгээ эзэмшиж байгаа иргэний мэдээлэл, гэрчилгээний хүчинтэй хугацааг байгууллагын цахим хуудас [www.pcsp.gov.mn](http://www.pcsp.gov.mn), төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)-д хайлт хийх боломжтойгоор байршуулж, мэдээллийн нээлттэй байдлыг хангав.

2018 оны жилийн эцсийн дүнгээр, улсын хэмжээнд худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшигчийн гэрчилгээ бүхий нийт 12970 иргэн төрийн худалдан авах ажиллагааны цахим системд бүртгэлтэй байна.

Цахим худалдан авах ажиллагааны системийн сургалтыг худалдан авах ажиллагааны захиалагч байгууллага, тендерт оролцогч аж ахуйн нэгжийн төлөөлөлд нийт 89 удаа зохион байгуулж, 2014 албан хаагч, иргэнийг оролцуулан чадавхижуулсан.

Архангай аймгийн захиалагч байгууллагуудын 24 албан хаагчид 2018 оны 6 дугаар сарын 8-ны өдөр, Өмнөговь аймагт 2018 оны 08 дугаар сарын 07-09-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Салбарын албан хаагчдын зүүн бүсийн уулзалт”-д оролцож, худалдан авах ажиллагааны цахим системийн сургалтыг тус тус зохион байгуулсан.

1.4.6. Төрийн бус байгууллага болон мэргэжлийн холбоодын шинэчилсэн бүртгэл хийх зарыг байгууллагын цахим хуудас [www.pcsp.gov.mn](http://www.pcsp.gov.mn) -д 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл байршуулан нээлттэй зарлан мэдээлсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4-т заасны дагуу худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажиллах хүсэлтэй төрийн бус 54 байгууллагын 80 төлөөлөлтэй хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулсан. Тэдгээрээс сонгон шалгаруулах зарчмаар нэг

үнэлгээний хороонд төрийн бус байгууллагын 2 төлөөллийг оролцуулан үнэлгээний хороог байгуулан ажиллуулж байна. Худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажиллах төрийн бус байгууллагын гишүүнд худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшсэн байх шалгуурыг тавьж, шаардлага хангасан төлөөллийг сонгон шалгаруулж ажиллуулсан болно.

2019 онд хамтран ажиллах Төрийн бус байгууллага болон мэргэжлийн холбоодын шинэчилсэн бүртгэл хийх зарыг байгууллагын цахим хуудас <http://pcsp.gov.mn> –нд байршуулаад байна.

1.4.7. 21 аймгийн Орон нутгийн өмчийн газар, Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар, 9 дүүргийн Худалдан авах ажиллагааны албаны 2018 оны худалдан авах ажиллагааны 1, 2, 3 дугаар улирлын худалдан авалтын мэдээг батлагдсан маягтын дагуу хүлээн авч нэгтгэн хяналт тавьж ажиллав. 2018 оны 3 дугаар улирлын тайлангийн дүнгээр (өссөн дүн), орон нутгийн худалдан авах ажиллагааны 31 нэгжид 977.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 3006 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн.

Нийт төсөл, арга хэмжээний 88.6 хувь буюу 872.0 тэрбум төгрөгийн 2665 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулагдсан, 0.7 хувь буюу 1.4 тэрбум төгрөгийн 19 төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг боловсруулж байгаа, 10.7 хувь буюу 103.6 тэрбум төгрөгийн 322 төсөл, арга хэмжээ нь тодотголоор хасагдсан, зураг төсөв, ажлын даалгаваргүй гэсэн шалтгаанаар зохион байгуулагдаагүй.

Зохион байгуулагдсан худалдан авах ажиллагааны явц, үр дүн:

- 738.5 тэрбум төгрөгийн 2534 (84.2%) төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсны дүнд 41.1 тэрбум төгрөгийн хэмнэлт гарсан;
- 119.3 тэрбум төгрөгийн 80 (2.7%) төсөл, арга хэмжээний үнэлгээ хийгдэж байгаа;
- 14.2 тэрбум төгрөгийн 51 (1.7%) төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг олгох, тендер хүлээн авах шатанд байна.

Орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжид зохион байгуулагдсан худалдан авах ажиллагааны 95.0 хувийг цахим хэлбэрээр зохион байгуулсан байна.

2018 оны 3 дугаар улирлын байдлаар, зохион байгуулагдсан 2665 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны 3.7 хувь буюу 99 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтад Сангийн яам, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт гомдол гарсан.

Орон нутгийн худалдан авах ажиллагааны 2018 оны жилийн эцсийн тайланг орон нутгийн нэгжүүдээс хүлээн авч байгаа бөгөөд нэгтгэл, дүн гарч дуусаагүй байна. 2019 оны 1 сард дүн гарч дуусна.

1.4.8. 2019 онд ТӨБЗГ-т зохион байгуулах худалдан авах ажиллагааны жагсаалт батлах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар 2018 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тусгуулан, жагсаалтын төслийг боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Жагсаалтын төслийг 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, 388 дугаар тогтоолоор баталсан. Уг тогтоолын 1 дүгээр хавсралтаар 9 төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 420.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 194 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2019 онд ТӨБЗГ-т зохион байгуулахаар батлагдсан. Мөн тогтоолын 3 дугаар хавсралтаар ерөнхий гэрээ байгуулах замаар худалдан авах зарим ерөнхий нэршлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, чанар, стандартын шаардлага хангасан дотоодод үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний жагсаалт батлагдсан.

21 аймаг, нийслэл, дүүрэг, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 160 гаруй байгууллагаас “Ерөнхий гэрээ”-гээр худалдан авах бараа, бүтээгдэхүүний мэдээлэл авч, эрэлт нийлүүлэлтийн судалгаа хийсэн.

2019 онд ТӨБЗГ-т зохион байгуулах худалдан авах ажиллагааны жагсаалт Засгийн газрын 2018 оны 388 дугаар тогтоолоор батлагдсантай холбогдуулан холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нартай худалдан авах ажиллагааны хамтарсан төлөвлөгөө батлуулахаар ТӨБЗГ-ын 2018 оны 12 дугаар сарын 28-ны А-1/4805 тоот албан бичгийг 9 төсвийн захирагчид хүргүүлэв. Уг хамтарсан төлөвлөгөө батлагдсанаар 2019 онд зохион байгуулагдах худалдан авах ажиллагааны ерөнхий зохион байгуулалт хангагдана.

#### 1.5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх ажлын чиглэлээр

1.5.1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг авлигын эсрэг хууль тогтоомж болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх ажлуудыг тусгасан нийт 33 заалттайгаар боловсруулж, газрын даргын 2018 оны А/85 дугаар тушаалаар батлуулав. Уг төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах хүрээнд дотоод сүлжээ [www.able.mn](http://www.able.mn) –д байршуулан нийт албан хаагчид мэдээлэн сурталчилж, газрын цахим хуудас [www.pcsp.gov.mn](http://www.pcsp.gov.mn) –д байршуулж, олон нийтэд нээлттэй мэдээлсэн.

1.5.2. Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2017 оны хэрэгжилтийг ТӨБЗГ-ын хариуцан болон хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан, нийт 3 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 15 арга хэмжээний хүрээнд нэгтгэн боловсруулж, 70 хувийн гүйцэтгэлтэй буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээтэйгээр 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А-1/298 дугаар албан бичгээр, 2018 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг ТӨБЗГ-ын хариуцан болон хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан, нийт 4 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 17 арга хэмжээний хүрээнд нэгтгэн боловсруулж, 70 хувийн гүйцэтгэлтэй буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээтэйгээр цахим хэлбэрээр Авлигатай тэмцэх газарт тус тус хүргүүлсэн. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд байгууллагын цахим хуудсанд тусгай цэс үүсгэн АТГ-аас ХАСУМ хянаж ирүүлсэн дүгнэлтийг байршуулж, олон нийтэд ил тод мэдээлэх бэлтгэлийг хангасан.

1.5.3. Авлигатай тэмцэх газраас Монгол Улсын Засгийн газарт 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 01/8836 дугаар албан бичгээр хүргүүлсэн “Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж”-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах чиглэлээр 28 заалт бүхий төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг ханган ажиллав. Уг төлөвлөгөөний биелэлтийг 2018 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар гаргаж, ЗГХЭГ болон АТГ-т А-1/3601 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах хүрээнд Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсээс харьяа төрийн өмчит хуулийн этгээдэд 2018 оны А-1/350 дугаар албан бичгээр албан даалгавар хүргүүлж, биелэлтийг тооцсон.

1.5.4. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан авлигын эсрэг 30 удаагийн багц сургалтад ТӨБЗГ-ын 72 албан хаагч, харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн 488 ажилтан, нийт 560 хүнийг хамруулах ажлыг зохион байгуулав.

Мөн 2018 оны 01 дүгээр сарын 12, 12 дугаар сарын 13-ны өдөр АТГ-аас зохион байгуулсан 2 удаагийн сургалтад төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, ТӨҮГ-ын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах 100 (давхардсан тоогоор) ЭБАТ-ыг хамруулж, зохион байгуулалтаар хангаж ажиллав.



1.5.5. Авлигын эсрэг хууль тогтоомжийн дагуу мэдүүлэг гаргагч албан хаагчдад мэдүүлгээ хугацаанд нь үнэн зөв мэдүүлэх талаар мэдээлэл, зөвлөгөөг тухай бүр өгч ажиллав. 2017 оны ХАСХОМ-ийг шинэчлэн гаргах ажилтай холбоотойгоор ТӨБЗГ-ын 65 мэдүүлэг гаргагч, харьяа ТӨХЭ-ийн 74 удирдлага, 76 хуулийн этгээдийн ЭБАТ, нийт 215 албан хаагчтай нэг бүрчлэн мэдүүлэг мэдүүлэх, түүнийг бүртгэх, мэдээ тайланд тусгахад анхаарах асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгч, арга зүйгээр ханган ажиллав.

2018 онд шинээр албан тушаалд томилогдсон 9 (ТӨБЗГ - 5, захирал - 4), их хэмжээний өөрчлөлтийг мэдүүлсэн 4 (ТӨБЗГ - 1, захирал - 3), нийт 13 мэдүүлэг гаргагчид арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн байна.

1.5.6. Авлигатай тэмцэх газрын шалгалтын баг, авлигын эрсдэлийн үнэлгээ хийх судалгааны багт тус тус дэмжлэг үзүүлж, албан тушаалд нэр дэвшигчдийн ХАСУМ хянуулсан байдлын судалгаа, танилцуулга, ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар гаргасан мэдэгдэл, тайлбар, түүний шийдвэрлэлтийн талаарх судалгаа, танилцуулга, АТГ-аас ирүүлсэн хариутай бичгийн шийдвэрлэлтийн талаарх судалгаа, танилцуулга, давхар ажил эрхлэлтийн судалгаа, дүгнэлт, авлигын эрсдэлийн үнэлгээнд шаардлагатай гэж үзсэн байгууллагын стратеги, үйл ажиллагаатай холбоотой судалгааны материалыг гарган өгсөн.

1.5.7. Мэдүүлэг, мэдэгдэл бүрдүүлэлтийн ажлын хүрээнд: Авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн дагуу ТӨБЗГ-ын мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажлыг зохион байгуулж, 2017 оны мэдээ тайланг 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А-2/557 дугаар албан бичгээр АТГ-т хуулийн хугацаанд хүргүүлсэн. Уг тайланд ТӨБЗГ, харьяа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 76 хуулийн этгээдийн мэдүүлгийн бүрдүүлэлтийн тайлан мэдээллийг хамруулсан. Нийт 77 хуулийн этгээдийн 1195 мэдүүлэг гаргагч 2017 оны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд шинэчлэн мэдүүлсэн. Мэдүүлгийн бүрдүүлэлтийн 2017 оны тайлангийн зарим тоон үзүүлэлтийн дурдвал:

- ТӨБЗГ, харьяа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 76 хуулийн этгээд хамрагдсан;
- Албан тушаалд нэр дэвшсэн 291 нэр дэвшигчийн ХАСУМ-ыг бүртгэж, хянуулсан;
- 2017 онд хөрөнгө, орлогод орсон их хэмжээний өөрчлөлтийг мэдүүлсэн 66 мэдүүлэг (2016+)-ийг хүлээн авч, баталгаажуулсан;
- Шинээр томилогдсон 136 албан хаагч томилогдсоноос хойш 30 хоногийн дотор мэдүүлэг (2016\*)-ийг мэдүүлсэн;
- ХАСХОМ-ийг нийт 1195 мэдүүлэг гаргагч шинэчлэн (2017) мэдүүлсэн;
- Ашиг сонирхлын зөрчилтэй эсэх тухай 2987 мэдэгдлийг хүлээн авч бүртгэлд хамруулснаас 3 албан хаагч ашиг сонирхлын зөрчил үүсч байгааг мэдэгдсэн.

2018 оны мэдүүлэг бүрдүүлэлтийн ажлын явцыг 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар харуулбал:

- Албан тушаалд нэр дэвшигчдийн 201 ХАСУМ-ийг хүлээн авч бүртгэн АТГ-т хүргүүлж хянуулсан (10 нэр дэвшигч ТӨБЗГ-ын ажлын байрны сул орон тоонд, ТӨБЗГ-ын 30 албан хаагч ТУЗ-ийн гишүүнээр, 14 нэр дэвшигч төрийн өмчит хуулийн этгээдийн захирлаар томилогдохоор, төрийн бусад байгууллагын 99 албан хаагч ТУЗ-ийн гишүүнээр, 48 иргэн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр нэр дэвших),
- ХАСХОМ (2017) шинэчлэн гаргасан – 139 (ТӨБЗГ-65, захирал-74),
- Мэдүүлэг гаргах албан тушаалд томилогдож, ХАСХОМ (2017\*)-ийг шинээр гаргасан – 25 (ТӨБЗГ-11, захирал-14),

- Хөрөнгө орлогод нь их хэмжээний өөрчлөлт орж, ХАСХОМ (2017+)-ийг мэдүүлсэн – 7 (ТӨБЗГ-2, захирал-5),
- Нийт 171 (ТӨБЗГ-78, захирал-93) ХАСХОМ-ийг хүлээн авч, цаасаар болон цахим системд бүртгэн баталгаажуулсан байна. ХАСХОМ-ийг хугацаа хоцроож мэдүүлсэн болон огт мэдүүлээгүй тохиолдол гараагүй.

Мөн албан хаагчид үнэлгээний хороо, ажлын хэсгийн бүрэлдэхүүнээр томилогдон ажиллах, төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, захиргааны акт гаргах үедээ ашиг сонирхлын зөрчилтэй эсэх тухай нийт 698 мэдэгдэл, тайлбар гаргасныг бүртгэж авсан. Тэдгээрээс 11 тохиолдолд ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай, 687 нь ашиг сонирхлын зөрчилгүй гэж мэдэгдсэн. Нийт бүртгэгдсэн ашиг сонирхлын зөрчилтэй эсэх тухай 698 мэдэгдлийн 620-ыг худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд ажиллахдаа, 54-ийг хяналт шалгалт хийхэд, 24-ийг нь захиргааны шийдвэр гаргахдаа мэдэгдсэн байна.

1.5.8. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар шаардлагатай үед хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах, ашиг сонирхлын зөрчилтэй эсэх тухай мэдэгдэл, тайлбар гаргах талаар чиглэл, зөвлөмж боловсруулан 2018 оны А-1/2869 дугаар албан бичгээр харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад хүргүүлсэн.

1.5.9. Засгийн газрын шийдвэрээр хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээдэд өөрчлөлт орсонтой холбогдуулан эрчим хүчний салбарын 24, уул уурхайн салбарын 1 компанийн мэдүүлгийн бүрдүүлэлтийн харьяаллыг шилжүүлэхтэй холбоотой тайлбар, санал боловсруулж, ТӨБЗГ-ын 2018 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А-1/4621 тоот албан бичгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн шийдвэрлүүлсэн.

#### 1.6. Байгууллагын хүний нөөцийн асуудлаар

1.6.1. *Хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:* ТӨБЗГ-ын сул орон тоонд хууль тогтоомжид заасан шаардлага хангасан 5 албан хаагчийг төрийн жинхэнэ албанд томилон, тангараг өргүүлж, төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт өгч тэнцэн төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдсэн 2 албан хаагч, 7 төрийн үйлчилгээний албан хаагчийг тус тус шинээр томилж, 8 албан хаагчийг чиг үүрэг өөрчилсөн болон хэлтэс хооронд шилжүүлж, 8 албан хаагчийг Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу албан тушаалаас чөлөөлсөн.

2018 онд албан хаагчдын хөдөлмөрийн харилцааг зохицуулсан нийт 123 тушаал гарсаныг ангилан харуулбал:

- Албан тушаалд томилох тухай - 31
- Албан тушаалаас чөлөөлөх тухай - 11
- Тэтгэмжтэй чөлөө олгох тухай - 21
- Тусламж олгох тухай - 12
- Сахилгын шийтгэл ногдуулах тухай - 2
- Сургалтад оролцуулах тухай - 20
- Шагнах тухай - 6
- Бусад - 20

Давхардсан тоогоор 61 албан хаагчид цалингийн тодорхойлолт гарган өгч, ТӨБЗГ-ын 70 албан хаагчид ажлын үнэмлэх олгож, 31 төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад ажлын үнэмлэх олгож, албан хаагчдын НД-ийн дэвтэр, эмнэлгийн лист, чөлөөний хуудас, ээлжийн амралтын хуудас зэрэгт шаардлагатай тэмдэглэл, бичилтүүдийг тухай бүрт нь хийсэн.

Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн програмд газрын 77 албан хаагчийн 2017 оны мэдээллийг шивж оруулан, Төрийн албаны зөвлөлд 2018 оны 02 дугаар сарын 13-ны өдөр хүргүүлсэн. 2018 оны хүний нөөцийн мэдээллийг Төрийн албаны зөвлөд 2019 оны 01

дүгээр сарын 16-ны өдрийн дотор хүргүүлэхээр бэлтгэл ажлыг ханган тус програмд оруулж байна.

Албан хаагчдын шагнал, гадаад, дотоод томилолт, ажилласан жил, орон сууц, ажлын үнэмлэх, шаардлагатай үед холбоо барих хүний, хүүхдийн судалгааг шинэчилж газрын удирдлагад, дипломат болон албан паспорт эзэмшигчдийн судалгааг ЗГХЭГ, Гадаад харилцааны яаманд, АТГ-аас ТӨБЗГ-т ажиллах удирдамжтай холбогдуулан хүний нөөцийн 2 асуудлаар танилцуулга, холбогдох 7 судалгааг шинэчлэн гаргаж тус газраас ажилласан ажлын хэсэгт, Төрийн албаны зөвлөлөөс шаардсан хүний нөөцийн хөдөлгөөний судалгаа, намын байгууллагад ажиллаж байсан албан хаагчийн судалгааг тухай бүр хугацаанд нь гарган хүргүүлсэн.

2018 онд 85 (давхардсан тоогоор) албан хаагчтай үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулсан.

2018 оны эхний хагас жилд 67 албан хаагчийн үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээний биелэлтийг дүгнэх ажлыг зохион байгуулсан бөгөөд 39 (58 %) А буюу маш сайн, 22 (33 %) В буюу сайн, 5 (8 %) С буюу хангалттай, 1 (1 %) Д буюу дутагдалтай дүгнэгдэж, 6 захиргааны чөлөөтэй, шинээр томилогдсон шалтгаанаар дүгнээгүй.

2018 оны жилийн эцсээр 74 албан хаагчийн үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээний биелэлтийг дүгнэх ажлыг зохион байгуулсан бөгөөд 64 (89%) А буюу маш сайн, 7 (10%) В буюу сайн, 1 (1%) С буюу хангалттай, 1 албан хаагч захиргааны чөлөөтэй шалтгаанаар, 1 албан хаагчийг дүгнээгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолын хэрэгжилт хангах, Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах зорилгоор 2018 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн газрын даргын А/240 дугаар тушаалаар Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/ болон төрийн албаны сахилга хариуцлагын талаар өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан, 14 ажил бүхий төлөвлөгөө боловсруулан ажилласан.

Энэхүү төлөвлөгөөний хүрээнд 5 удаагийн сургалт зохион байгуулж, Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн асуудлаар 40 асуулт бүхий, 3 хувилбар сорилын шалгалт авч, байгууллагын чиг үүргийн шинжилгээ, албан хаагчдын ажлын байрны ачаалал, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах судалгаа хийж, газрын албан хаагчид болон иргэд, байгууллагаас бичгээр ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх арга хэмжээг авч, гадуур ажилтай албан хаагчдын мэдээллийг өдөр бүр гаргаж Төрийн тусгай хамгаалалтын газрын Харуул хамгаалалтын албаны ажилтанд өгч, газрын удирдлагын шуурхайг 7 хоног бүрийн Даваа гарагт хийж хэвшүүлсэн. Мөн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолын хэрэгжилт ханган ажиллах үүргийг 2018 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн А-2/3440 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

2018 онд ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ ажил төлөвлөсөн хугацаанд биелүүлээгүй, ажлын цагийг үр бүтээлтэй ашиглаагүй 2 албан хаагчид Төрийн албаны тухай хууль болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журмын дагуу сануулах сахилгын шийтгэл ногдуулж, 1 албан хаагчийн асуудлыг ТӨБЗГ-ын “Ёс зүйн хороо”-оор хэлэлцэн, сануулга өгч, бусад албан хаагчдад зөвлөмж хүргүүлсэн.

Тайлант хугацаанд, байгууллагын дотоод сүлжээнд нэвтрэх эрхийг шинээр ажилд орсон албан хаагчдад олгож, дотоод сүлжээгээр саадгүй харилцах боломжийг бүрдүүлэн, газрын дотоод хэрэгцээнд ашиглагдах баримт материал, мэдээ мэдээлэл, зар зэргийг дотоод сүлжээ ашиглан шуурхай хүргэн ажиллав. Мөн албан хаагчдын цаг ашиглалт,

ажлын бүтээмжийг сайжруулах талаар цаг бүртгэлийн системээр хяналт тавин, сар бүр цагийн бүртгэлийг гарган хэлтэс, албаны даргад танилцуулан, хэлтэс, албадын дарга нар өөрийн эрхээр нэвтрэн орж, албан хаагчдад хяналт тавих боломжоор хангасан. Мөн гадуур ажилтай албан хаагчдын мэдээллийг өмнөх өдөр нь гаргаж Төрийн тусгай хамгаалалтын газрын Харуул хамгаалалтын албаны ажилтанд өгч хэвшсэн.

1.6.2. *“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд:* 2018 оны 05 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд “Эрдэнэт үйлдвэр” ХХК-тай хамтран “Медипас” эмнэлэгт 10 албан хаагчийг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан. Мөн албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах зорилгоор Улсын 2 дугаар төв эмнэлэгтэй хамтран ажиллах тухай албан бичгийг хүргүүлж газрын удирдлага, хэлтэс, албаны дарга нарыг хамруулахаар болсон. 2018 оны 11 дүгээр сард нийт албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах тухай хүсэлтийг Эрүүл мэндийн яаманд хүргүүлж, Улсын II эмнэлэгийн үзлэгт хамруулахаар шийдвэрлүүлсэн.

Албан хаагчдын нийгмийн даатгалын дэвтэр, холбогдох судалгааг үндэслэн ажилласан жилийн баталгаажуулалтыг тулгаж, төрийн алба хаасан хугацаа, төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв шинээр авах болон шинэчлэн тогтоох албан хаагчдын судалгааг гаргасан. Энэхүү судалгааг үндэслэн Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын дагуу 13 албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн хэмжээг газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн Б/03, 2018 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн Б/59 дугаар тушаалаар олгосон. Мөн 1 албан хаагчийн цалингийн шатлалыг МУ-ын Сангийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 162 дугаар тушаалаар улсын ахлах байцаагчын цол олгогдсоныг үндэслэн 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн Б/113 дугаар тушаалаар шинэчилсэн.

Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв шинээр олгох болон шинэчлэн тогтоох болзол хангасан албан хаагчийн судалгааг гарган, 24 албан хаагчид зэрэг дэв олгуулах хүсэлтийг 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А-1/282, 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А-1/4345 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т тус тус хүргүүлсэн. ЗГХЭГ-ын даргын 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 135 дугаар тушаалаар 22, ЗГХЭГ-ийн тэргүүн дэд даргын 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 158 дугаар тушаалаар 11, нийт 33 албан хаагчид албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон шинэчлэн олгосон.

Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журмын дагуу үр дүнгийн гэрээний биелэлтийн эхний хагас жилийн үнэлгээг харгалзан 72 албан хаагчид нийт 35,794,052.00 (гучин таван сая долоон зуун ерэн дөрвөн мянга тавин хоёр) төгрөгийн урамшууллыг ТӨБЗГ-ын даргын 2018 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн А/215, жилийн эцсийн үнэлгээг харгалзан 71 албан хаагчид нийт 21,582,534.00 (хорин нэгэн сая таван зуун наян хоёр мянга таван зуун гучин дөрөв) төгрөгийн урамшууллыг ТӨБЗГ-ын даргын 2018 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн А/121 дугаар тушаалаар тус тус олгосон.

Гэр бүлд нь шинээр хүүхэд мэндэлсэн 3 албан хаагчид тус бүр 100.0 мянган төгрөг, ар гэрт нь гачигдал тохиолдсон 5 албан хаагчид тус бүр 200.0 мянган төгрөг, гэр хороололд шугам сүлжээнд холбогдоогүй байр орон сууцанд амьдардаг 4 албан хаагчид тус бүр 300.0 мянган төгрөг, хүндээр өвдсөн 1 албан хаагч, эцэг нь хүндээр өвдсөн 1 албан хаагчид тус бүр 1 сарын үндсэн цалинтай тэнцэх тэтгэмж олгов. Эх үрсийн баяраар албан хаагчдын 102 хүүхдэд нийт 2.5 сая төгрөгийн бэлэг өгөв.

Мөн Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Үйл ажиллагааны нэмэлт орлого зарцуулах тухай” А-294 дугаар тушаалаар олгогдсон эрхийн хүрээнд 64 албан хаагчид 120.8 сая төгрөгийн урамшууллыг ТӨБЗГ-ын даргын 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/295 дугаар тушаалаар, 10 албан хаагчид 116 сая төгрөгийн орон

сууцны дэмжлэгийг 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/293 дугаар тушаалаар тус тус олгосон.

Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 97 жилийн ой, Шинэ жилийг тохиолдуулан ТӨБЗГ-т үр бүтээлтэй ажиллаж, эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан 1 албан хаагчийг “Алтан гадас” одонгоор, 6 албан хаагчийг ТӨБЗГ-ын “Жуух бичиг”-ээр, 4 албан хаагчийг “Салбарын тэргүүн”, 3 албан хаагчийг салбарын “Хүндэт жуух” бичгээр, 7 албан хаагчийг Залуучуудын холбооны шагнал, 5 албан хаагчийг ТӨБЗГ-ын “Тусгай мөнгөн шагнал”-аар, нийт 26 албан хаагчийг шагнасан. Шагнагдсан албан хаагчдын мэдээллийг 3 дугаар хүснэгтээр харуулав.

3 дугаар хүснэгт

Шагнал авсан албан хаагчдын жагсаалт

Д/д	Шагналын нэр	Овог нэр	Албан тушаал
1	Алтангадас одон	Д.Нарангэрэл	Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
<i>Салбарын тэргүүн</i>			
2	“Мэдээлэл, харилцаа холбооны тэргүүний ажилтан”	Н.Цэрэнсамбуу	Мэдээлэл технологийн албаны дарга
	“Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан”	Э.Ганчимэг	“Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан”
	Хууль зүйн салбарын “Тэргүүний ажилтан”	П.Туул	Захиргаа, хууль зүйн хэлтсийн архивын ажилтан
	“Санхүү, банкны тэргүүний ажилтан”	С. Чинбат	Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн
<i>Салбарын жуух бичиг</i>			
3	Сангийн яамны “Жуух бичиг”	Ж. Мөнхтүвшин	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын ахлах нягтлан бодогч
	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын “Хүндэт жуух бичиг”	Ч.Ганбаяр	Мэдээлэл, технологийн албаны мэргэжилтэн
	Зам тээврийн салбарын “Хүндэт жуух бичиг”	Д.Одмаа	Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
4	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын “Хүндэт жуух”	Ц.Баяр-Эрдэнэ	Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн дарга
		Ц. Түвшинзаяа	Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн дарга
		Л.Лхамсүрэн	Худалдан авах ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн
		Л. Сэлэнгэ	Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн
		Т. Лхагвасүрэн	Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
		У. Батзаяа	Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн
5	Залуучуудын холбооны шагнал	А.Алтаншагай	Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн мэргэжилтэн
		Т.Хулан	Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
		Э.Тамир	Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн
		Б. Гэрэлтуяа	Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн мэргэжилтэн
		М. Болор	Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
		Х. Дашдаваа	Захиргаа, хууль зүйн хэлтсийн орон нутаг хариуцсан мэргэжилтэн
		Ц. Лхагвасүрэн	Мэдээлэл, технологийн албаны мэргэжилтэн
6	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын “Тусгай мөнгөн шагнал”	Д.Дэлгэрмаа	Захиргаа, хууль зүйн хэлтсийн хууулийн мэргэжилтэн
		Л.Нандинцэцэг	Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн
		Д.Алтанцэцэг	Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн

	Г.Дэлгэрмаа	Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн мэргэжилтэн
	Ц.Шинэхүү	Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Сурагчдын зуны амралтыг тохиолдуулан албан хаагчдын хүүхдийн зусланд амрах судалгааг гарган “Найрамдал” ОУХ-ийн төвд 13 хүүхэд амруулах хүсэлт хүргүүлэн, эрхийн бичгийг захиалан амрах боломжоор хангасан.

Байгууллагын олон нийтийн ажлыг зохион байгуулах үүрэг бүхий комиссыг шинэчлэн байгуулахад хэлтэс, албаны дарга нараас санал авч, ТӨБЗГ-ын даргын 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/47 дугаар тушаалаар байгуулсан. Олон нийтийн ажлын хэсгийн 2018 онд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 14 үйл ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөн Цагаан сарын баярыг тохиолдуулан 2018 оны 02 дугаар сарын 12-ны өдөр ахмадуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх, 02 дугаар сарын 19-ний өдөр албан хаагчдын золголт, 03 дугаар сарын 03-ны өдөр “Цасны баяр”, 03 дугаар сарын 18-ны өдөр “Монгол цэргийн өдөр”, 05 дугаар сарын 30-ны өдөр “Хүүхдийн баяр”, 7 дугаар сарын 09-ны өдөр Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 97 жилийн ой, 9 дүгээр сарын 28-ны өдөр Олон улсын ахмадын баяр, 10 дугаар сарын 13-ны өдөр мод тарих, 10 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд албан хаагчдыг витаминжуулах, 10 дугаар сарын 24-ны өдөр цус хандивлах, ажлын байр цэцэгжүүлэх арга хэмжээ, 12 дугаар сарын 19-ний өдөр “Шинэ жил 2018-2019” арга хэмжээний бэлтгэлийг тус тус ханган зохион байгуулж, төлөвлөгөөг хэрэгжүүлсэн.

1.6.3. “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн сургалтын хөтөлбөр”-ийн хүрээнд: Албан хаагчид албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг чадварыг дээшлүүлэх, байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн сургалтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд газрын 2018 оны сургалтын төлөвлөгөөг холбогдох хэлтэс, албаны саналыг тусган боловсруулж, 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/38 дугаар тушаалаар батлуулсан. Тус тушаалын 1 дүгээр хавсралтаар ТӨБЗГ-ын албан хаагчдын, 2 дугаар хавсралтаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, ажилтны, 3 дугаар хавсралтаар Орон нутгийн өмчийн газрын албан хаагчдын сургалтын төлөвлөгөөг тус тус баталсан. Энэхүү төлөвлөгөөний дагуу дараах сургалтыг зохион байгуулсан. Үүнд:

1.6.3.1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдын сургалт. Газрын албан хаагчдад 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/38 дугаар тушаалын хүрээнд 35, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгавар, 2018 оны “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолын хэрэгжилт хангах, Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах зорилгоор 5, ТӨБЗГ-ын албан хаагчдыг соён гэгээрүүлэх, шинэ мэдлэг, мэдээлэл олгох сургалтын хүрээнд 4, ТӨБЗГ-ын албан хаагчдад “Хууль тогтоомж, сурталчлах сарын аян”-ны хүрээнд 11, нийт 55 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 1608 албан хаагчийг хамруулсан. Сургалтыг агуулгаар нь ангилан харуулбал. Үүнд:

- Хууль тогтоомжийн сургалт 20,
- АТГ-ын төлөвлөгөөт сургалт 23,
- Мэргэшүүлэх сургалт 3,
- Соён гэгээрүүлэх 9.

Удирдлагын академийн төрийн захиргааны менежментээр мэргэшүүлэх сургалтад Мэдээлэл технологийн албаны мэргэжилтэн Б.Мөнхзул, В.Азжаргал, магистрийн сургалтад Худалдан авах ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Эрдэнэбулган



нарыг Засгийн газрын тэтгэлэгээр, Захиргаа, хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн М.Лхагважав, Э.Эрдэнэбаатар, Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн М.Болор, Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн Э.Тамир нарт их, дээд сургуульд суралцах хугацаанд нь цалинтай чөлөө олгож байна.

Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Ө.Батбаатар, мэргэжилтэн С.Энхзориг нарыг 2018 оны 4 дүгээр сарын 23-ны өдрөөс 27-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос улсын Гояанг хотод зохион байгуулагдсан “Төрийн худалдан авах ажиллагаа-2018” туршлага судлах сургалтад, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дэд дарга А.Дагвадорж, Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Нарангэрэл, Захиргаа, хууль зүйн хэлтсийн хуулийн ахлах мэргэжилтэн Э.Эрдэнэхишиг нарыг 2018 оны 6 дугаар сарын 24-ний өдрөөс 30-ны өдрүүдэд Холбооны Бүгд Найрамдах Герман улс болон Шведийн Вант улсад зохион байгуулагдсан “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах” сургалтад, Мэдээлэл, технологийн албаны ахлах мэргэжилтэн С.Халиун, Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн мэргэжилтэн Д.Золбоо нарыг 2018 оны 8 дугаар сарын 26-ны өдрөөс 9 дүгээр сарын 15-ны өдрүүдэд БНСУ-ын Бусан хотод “Койка” олон улсын байгууллагаас зохион байгуулсан “Төрийн өмчийн удирдлага, үйл ажиллагааг чадавхжуулах” сэдэвт сургалтад, Мэдээлэл, технологийн албаны мэргэжилтэн Д.Бадрахыг 2018 оны 9 дүгээр сарын 03-ны өдрөөс 23-ны өдрүүдэд Бүгд найрамдах Хятад Ард Улсын Харбин хотын худалдааны их сургуульд зохион байгуулсан “Хил дамнасан цахим худалдаа туршлага судлах” сургалтад, нийт 8 албан хаагчийг 4 улсад сургалтад хамруулсан.

1.6.3.2. *Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ажилтанд зориулсан сургалт.* Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ажилтанд зориулсан 4 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтын мэдээллийг зураг 4-7-д харуулав. Үүнд:

1. 2018 оны 4 дүгээр сарын 05, 06-ны өдрүүдэд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 51 хуулийн этгээдийн 150 Тэргүүн дэд захирал, ерөнхий инженер, Тамгын газрын дарга, хуулийн мэргэжилтэн, нууцын асуудал хариуцсан ажилтанг оролцуулсан семинарыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор нээж батлагдсан төлөвлөгөөний дагуу Захиргаа, хууль зүйн хэлтсийн дарга Э.Эрдэнэхишиг “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал”, “Удирдлагын үйл ажиллагаанд анхаарах зарим асуудал”, ТӨБЗГ-ын Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, удирдлагын менежментийг оновчтой зохион байгуулахад анхаарах асуудлууд”, “Мэдээлэл, технологийн үндэсний парк” ТӨҮГ-ын Инноваци технологи, судалгаа хөгжүүлэлтийн хэлтсийн дарга О.Хичээнгүй “Аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгал ба дижитал шилжилт”, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын менежер Я.Самбууням “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2016-2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил дутагдал”, ТӨБЗГ-ын Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Ө.Батбаатар “Төрийн өмчийн хяналт”, Д.Нарангэрэл “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, хөдөлгөөн, зохицуулалт, үнэлгээний асуудал”, Э.Ганчимэг “Төрийн өөрийн өмчийн түрээсийн харилцаа” сэдвээр, Удирдлагын академийн багш, доктор (Ph.D), дэд профессор Н.Цолмонтуяа “Ёс зүйн

5 дугаар зураг



менеджмент”, ТӨБЗГ-ын Мэдээлэл, технологийн албаны дарга Н.Цэрэнсамбуу “Худалдан авах ажиллагааны өнөөгийн байдал, шийдвэрлэх арга зам”, Эдийн засагч С.Болд “Эдийн засгийн дунд хугацааны төлөв хандлага”, Татварын ерөнхий газрын Удирдлага, хамтын ажиллагааны газрын татварын улсын ахлах байцаагч Б.Галбадрах “Татварын хууль тогтоомжид орсон өөрчлөлт”, Тагнуулын ерөнхий газрын Төрийн нууцын хэлтсийн ажилтан, ахмад Ч.Алтантөр “Төрийн болон албаны нууцын тухай ойлголт, эрх зүйн онцлог”, Тагнуулын ерөнхий газрын, Төрийн нууцын хэлтсийн ажилтан, ахмад Э.Номин “Төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтан, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага”, Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх, хэлтсийн ахлах ажилтан, ахлах комиссар Л.Нарантуяа “Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх”,

2. 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдөр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 100 хуулийн этгээдийн 112

6 дугаар зураг

санхүүгийн асуудал хариуцсан нэгжийн дарга, ерөнхий нягтлан бодогчдыг оролцуулсан семинарыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор нээж, ТӨБЗГ-ын Захиргаа, хууль зүйн хэлтсийн дарга Э.Эрдэнэхишиг чиглүүлж, батлагдсан хөтөлбөрийн дагуу Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын IV ерөнхийлөгч, “БДО аудит” ХХК-ийн захирал Г.Баянмөнх “Бидний мэргэжлийн ирээдүй”, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн “Нягтлан бодох бүртгэлийн бодлого, чиглэл”, Татварын ерөнхий газрын Татвар төлөгчтэй харилцах газрын татварын улсын байцаагч Н.Жаргалцэцэг “Нэмэгдсэн өртөгийн албан татварын асуудал”, Татварын ерөнхий газрын Татвар төлөгчтэй харилцах газрын татварын улсын байцаагч Н.Жаргалцэцэг, Ч.Болорцэцэг, Гааль, татвар, мэдээлэл технологийн төвийн инженер Х.Тайван нар “Цахим тайлан илгээх, хүлээн авах, төлбөрийн баримтын асуудал”, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын менежер Я.Самбууням “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2016-2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил дутагдал”, ТӨБЗГ-ын Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Нарангэрэл “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, хөдөлгөөн, зохицуулалт, үнэлгээний асуудал”,



3. 2018 оны 05 дугаар сарын 04-ний өдөр 92 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн захирлыг оролцуулсан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор нээж, ТӨБЗГ-ын Захиргаа, хууль зүйн хэлтсийн дарга Э.Эрдэнэхишиг чиглүүлж, ТӨБЗГ-ын Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Нарангэрэл “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, хөдөлгөөн, зохицуулалт, үнэлгээний асуудал”, Компанийн засаглалын хөгжлийн төвийн захирал, доктор Т.Цэнд-Аюуш “Компанийн засаглал”, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал Ц.Наранчимэг “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2016-2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил дутагдал”, Улсын ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор Э.Бадрал “Зөрчлийн тухай хууль”, ТӨБЗГ-ын Мэдээлэл, технологийн албаны дарга Н.Цэрэнсамбуу “Худалдан авах ажиллагааны өнөөгийн байдал, шийдвэрлэх арга зам”, ТӨБЗГ-ын Захиргаа, хууль зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Эрх бүхий албан тушаалтан Х.Энхчимэг “Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх”,



8 дугаар зураг



нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн

найруулгын төслийн үзэл баримтлалын зарим асуудал”, Компаний засаглалын үндэсний зөвлөлийн дарга Д.Ганбаяр “Компаний сайн засаглалыг хэрэгжүүлэхэд ТУЗ-ийн гишүүдийн үүрэг, оролцоо ба нийгмийн хариуцлага”, Компаний засаглалын хөгжлийн төвийн захирал, доктор Т.Цэнд-Аюуш “Компаний засаглал”, ТӨБЗГ-ын Захиргаа, хууль зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Эрх бүхий албан тушаалтан Х.Энхчимэг “Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх” сэдвээр тус тус лекц уншуулж зохион байгуулсан. Мөн тус семинаруудын тайланг боловсруулан, холбогдох материалаар архивын нэгж үүсгэсэн.

4. 2018 оны 05 дугаар сарын 04-ний өдөр 40 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн 72 Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг оролцуулсан семинарыг ТӨБЗГ-ын Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ нээж, ТӨБЗГ-ын Захиргаа, хууль зүйн хэлтсийн дарга Э.Эрдэнэхишиг чиглүүлж, батлагдсан хөтөлбөрийн дагуу ТӨБЗГ-ын Захиргаа, хууль зүйн хэлтсийн дарга Э.Эрдэнэхишиг “Компанийн тухай хууль, Төрийн болон орон

9 дүгээр зураг



Мөн 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн орлогч дарга О.Отгонбаяр ахлагчтай төслийн баг удирдлагын баримт бичгийн эргэлт, шийдвэрлэлтэд хяналт тавих ажлыг оновчтой зохион байгуулж буй талаар туршлага судалж, зөвлөгөө авахаар ажилласан. Уг төслийн багт зориулж Захиргаа, хууль зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Эрдэнэхишиг “Захиргааны акт, гэрээ хэрхэн боловсруулах, баталгаажуулах”, “Албан хэрэг хөтлөлтөд гардаг нийтлэг алдаа, дутагдал, анхаарах асуудал” сэдвээр, ахлах мэргэжилтэн Д.Наранчимэг “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдааны зохион байгуулалт, шийдвэр, түүнийг хэрэгжилтийг хангах”, ахлах мэргэжилтэн Х.Энхчимэг “Бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах, мэдээлэх”, “Авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилийг хангах, мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хянах”, бичиг хэргийн эрхлэгч М.Лхагважав “Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт”, “Дотоод сүлжээний ашиглалт”, архивын эрхлэгч П.Туул “Архивын баримтын тухай” сэдвээр тус тус мэдээлэл хийж, харилцан ярилцаж, туршлага солилцсон. Мэдээллийг 9 дүгээр зурагт харуулав.

1.6.3.3. *Орон нутгийн өмчийн газрын албан хаагчдад зориулсан сургалт.* 2018 онд орон нутгийн нэгжүүдийн албан хаагчдыг 3 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтын мэдээллийг 10-12 дугаар зургаар харуулав. Үүнд:

1. 2018 оны 01 дүгээр сарын 18,19-ний өдрүүдэд Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 15, 17 аймгийн Орон нутгийн өмчийн газрын 26, нийт 41 албан хаагчийг хамруулан “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-ийн сургалт зохион байгуулсан. Энэхүү сургалтын хөтөлбөрт Улсын ерөнхий прокурорын газар Зөрчлийн тухай хууль, ТӨБЗГ-ын Захиргаа, хууль зүйн хэлтсийн хуулийн ахлах мэргэжилтэн Э.Эрдэнэхишиг “Албан хэрэг хөтлөлт, албан бичиг боловсруулах арга зүй”, Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Э.Ганчимэг “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 2017 оны биелэлтийн дүнгээр авах арга хэмжээний тухай”,



10 дугаар зураг



Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Нарангэрэл “Хөрөнгийн дахин үнэлгээний бэлтгэл ажлыг хэрхэн хангах”, “2017 оны улсын нэгтгэлд анхаарах асуудал”, Мэдээлэл, технологийн албаны дарга Н.Цэрэнсамбуу, мэргэжилтэн Ц.Лхагвасүрэн нар “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем” сэдвээр сургалт хийж, Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн албан хаагчид “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-ийн дүүргэлтэд мониторинг хийж, дүүргэлтийг сайжруулах талаар 17 аймгийн Засаг даргад албан бичиг хүргүүлсэн.

2. “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем” болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн тулган баталгаажуулалтын ажлын хүрээнд Нийслэлийн өмчийн харилцааны газрын 7, 21 аймгийн Орон нутгийн өмчийн газрын 76 албан хаагч нийт 83 албан хаагчид “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын анхаарах асуудал Сангийн яамны мэргэжилтэн Б.Сугармаа, “Хөрөнгийн дахин үнэлгээ” ТӨБЗГ-ын ТӨБХХ-ийн ахлах мэргэжилтэн Д.Нарангэрэл, “Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх бодлого, зохицуулалт, анхаарах асуудал” БТУХ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, ахлах мэргэжилтэн В.Дарханбаатар, “Худалдан авах ажиллагааны өнөөгийн байдал”, “Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн систем” ХААХ-ийн дарга Х.Улам-Өрнөх, МТА-ны дарга Н.Цэрэнсамбуу, “Харилцаа, хандлага-зөв амьдрал” сэдвээр УИХ-ын гишүүн асан Ц.Товуусүрэн нар сургалт, Орон нутгийн өмчийн газарт хийсэн шалган зааварчлах ажлын дүн, түүний мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, зөвлөмжийн тухай ЗХЗХ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Эрдэнэхишиг мэдээлэл хийж мэргэжил арга зүйгээр хангасан.

11 дүгээр зураг



3.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 2018 оны 09 дүгээр сарын 06-08-ны өдрүүдэд Засгийн газрын 2016 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 193 дугаар тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг дахин үнэлж, санхүүгийн тайланд тусгах, үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлын хүрээнд нийслэл, 21 аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан ерөнхий ажлын хэсгийн гишүүд, Орон нутгийн өмчийн газар болон Нийслэлийн өмчийн харилцааны газрын албан хаагчдад “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний ажлыг зохион байгуулах сургалт”-ыг “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн байранд зохион байгуулсан. Тус сургалтад Орон нутгийн өмчийн газар болон Нийслэлийн өмчийн харилцааны газрын нийт 100 гаруй албан хаагчдад хамрагдсан бөгөөд Сангийн сайдын

12 дугаар зураг



2018 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 207 дугаар тушаалаар баталсан үнэлгээний аргачлалын дагуу гаргасан Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, дахин үнэлгээний гарын авлага, тараах материалаар хангасан. Батлагдсан хөтөлбөрийн дагуу 09 дүгээр сарын 06, 07-ны өдрүүдэд төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний аргачлал, Үнэлгээний ажлын удирдлага, зохион байгуулалтын заавар, УИХ-ын 61 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх, Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-ийн талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Нарангэрэл, Үнэлгээний аргачлалын үр дүнг санхүүгийн тайланд тусгах талаар Сангийн яамны ахлах мэргэжилтэн Г.Дариймаа, Хөрөнгийн үнэлгээний тухай ойлголт, Үнэлгээний Олон улсын стандартын талаар мэдлэг олгох, Сангийн сайдын баталсан үнэлгээний аргачлалаар хийсэн жишиг үнэлгээ, анхаарах асуудлаар ММҮИ-ийн тэргүүлэх үнэлгээчид Д.Барсболд, Б.Энхболд нар сургалт хийсэн. Мөн 09 дүгээр сарын 08-ны өдөр Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд тараан өгөх Сангийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 207 дугаар тушаалаар баталсан үнэлгээний аргачлалын дагуу гаргасан Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, дахин үнэлгээний 6000 гаруй гарын авлага, CD-г урьдчилсан байдлаар 21 аймгийн Орон нутгийн өмчийн газрууд, Нийслэлийн өмчийн харилцааны газар бусад төрийн байгууллагуудад хувиарлан тарааж, тус сургалтын хичээлийг 21 аймгийн өмчийн мэргэжилтнүүдэд цахимаар хүргүүлсэн.

## 1.7. Орон нутгийн ажлын чиглэлээр

### *1.7.1. Мэргэжил, арга зүйгээр хангах*

13 дугаар зураг

1. 2018 оны 03 дугаар сарын 12-18-ны өдрүүдэд 21 аймгийн Орон нутгийн өмчийн газартай орон нутгийн хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн тулган баталгаажуулалтыг хийж, албан хаагчдад сургалт, семинар зохион байгуулсан. Семинарын мэдээллийг зураг 12-т харуулав. Тус семинарт Нийслэлийн өмчийн харилцааны газрын 7, 21 аймгийн Орон нутгийн өмчийн газрын 76 албан хаагч нийт 83 албан хаагч хамрагдсан. Энэхүү арга хэмжээний хүрээнд 21 аймгийн Орон нутгийн өмчийн газрын албан хаагчдыг Нийслэлийн өмчийн харилцааны газрын үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлах уулзалтыг зохион байгуулсан. Тус сургалтын үеэр ТӨБЗГ-ын дарга Ц.Ням-Осор 21 аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарыг хүлээн авч уулзан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, орон нутагт тулгамдаж буй асуудлын талаар санал солилцсон. Орон нутгийн өмчийн газрын дарга нарын гаргасан саналыг нэгтгэн Засгийн газрын Хэрэг Эрхлэх газарт 2018 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А-1/902 дугаар албан бичгийг хүргүүлсэн. Энэхүү албан бичгийн дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт Орон нутгийн өмчийн газарт тулгамдаж буй асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, энэ чиглэлээр ТӨБЗГ-тай хамтран ажиллах тухай 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн ХЭГ/680 дугаар албан бичгийг хүргүүлж, хувийг ТӨБЗГ-т ирүүлснийг 21 аймгийн ОНӨГ-т хүргүүлсэн.



2. Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагааг шалган зааварчлах, төрийн болон орон нутгийн өмчит зарим компанийн үйл ажиллагаатай танилцах, заавар зөвлөгөө өгөх,

мэргэжил, арга зүйгээр хангах, төрийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийн үнэлгээ, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний сургалт зохион байгуулах удирдамж, төлөвлөгөө, ажиллах чиглэл, зардлын төслийг боловсруулан газрын даргын 2018 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/111 дүгээр тушаалаар батлуулж Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Өмнөговь, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл аймагт 7 ажлын хэсэг ажиллуулж, 16 төрийн байгууллага, 31 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд заавар зөвлөгөө өгч, мэргэжил, арга зүйгээр хангасан. Ажлын хэсгүүдийн мэдээллийг 14, 15 дугаар зургаар үзүүлэв.



Зураг 14. 06 дугаар сарын 11-18-ны өдрүүдэд Өмнөговь, Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газар, "Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн Дундговь салбар, Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, "Дундговь-Ус" ОНӨҮГ, "Даланзадгад дулааны цахилгаан станц" ТӨХК, "Гүний ус" ТӨХХК, "Тавантолгой" ХК-д



Зураг 15. 05 дугаар сарын 07-11-ны өдрүүдэд Говь-Алтай, Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газар, "Алтай-Улиастай эрчим хүчний систем" ТӨХК, "Алтай-Ундарга" ОНӨҮГ-т, "Богдын голын усан цахилгаан станц" ТӨХХК, "Амь ус трейд" ХХК-д,

## 1.8. Агентлагийн төсөв, санхүүгийн талаар

1.8.1. ТӨБЗГ-ын 2018 оны үйл ажиллагааны зардалд нийт 1,945.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 12 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар 1.882.7 тэрбум төгрөгийн санхүүжилт гарсан. 2018 оны төсвийн гүйцэтгэл 96.8%-тай, 63.2 сая төгрөгийн хэмнэлттэй байна.

Төсвийн зардлын санхүүжилт:

- Цалин хөлс болон НДШ-д - 883.1 сая төгрөг;
- Урсгал зардалд – 3.9 сая төгрөг;
- Хангамж, материалын зардалд – 103.0 сая төгрөг;
- Томилолтын зардалд – 232.3 сая төгрөг;
- Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд – 428.6 сая төгрөг;
- Бараа, үйлчилгээний бусад зардалд – 224.9 сая төгрөг;
- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулалд 6.8 сая төгрөг.

1.8.2. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй явуулах бэлтгэл ажлыг ханган 2018 онд 66,449.4 сая төгрөгийн бараа, материал, шатахуун шинээр татан авч, 2017 оны үлдэгдэл 7,592.519 сая төгрөгийн бараа материалыг анхан шатны баримтын бүрдлийг ханган, удирдлагаар хянуулан, удирдлагын зөвшөөрлийн дагуу 74,041.919 сая төгрөгийн бараа материал, шатахуун олгож, 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар бараа материалын үлдэгдэлгүй байна.

1.8.3. Газрын даргын А-181 дүгээр тушаалаар 7, А-286 дугаар тушаалаар 6 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй үндсэн хөрөнгийн тооллогын комиссыг байгуулж байгууллагын эд хөрөнгийг 2 удаа тоолсон. 2018 оны 01 дүгээр сарын 01-ны өдрийн байдлаар



22,253,520,193.52 төгрөгийн үнийн дүнтэй 1483 үндсэн хөрөнгө бүртгэлтэй байсан бөгөөд 2018 онд 674,587,126.45 төгрөгийн үнийн дүнтэй 6 автомашин, 1 тээврийн хэрэгсэл, 1 тавилга, аж ахуйн хэрэгсэл балансаас балансад шилжин ирж, 15,031,745,603.45 төгрөгийн 5 барилга байгууламж, 3 автомашиныг бусад байгууллагад балансаас балансад шилжүүлж, 104,373,787.90 төгрөгийн үнийн дүнтэй 156 тавилга, аж ахуйн хэрэгслийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 529 дугаар тогтоол, 2018 оны 11 сарын 29-ны өдрийн А-5/440 дугаар бичгээр тус тус шийдвэрлүүлэн акталж, данснаас хасч, 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 1328 ширхэг 7,791,987,928.62 төгрөгийн үнийн дүнтэй хөрөнгө бүртгэлтэй байна.

1.8.4. 2017 оны жилийн эцэс, 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хууль, журмын дагуу цаг хугацаанд нь төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэн, тайланг хамгаалж баталгаажуулсан.

Байгууллагын албан хаагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг сар бүрийн 5 –ны өдрийн дотор НД7, НД8 маягтын дагуу гарган нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлэн баталгаажилт хийлгэн, албан хаагчийн дэвтэрт сар бүрийн 10-ны өдрийн дотор бичилт хийж байна. Санхүү эдийн засгийн сайдын 2003 оны 49 тоот тушаалаар батлагдсан загварын дагуу төсвийн гүйцэтгэлийн зарлагын сарын мэдээг сар бүрийн 02-ны өдрийн дотор гарган Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж байна.

1.8.9. *Шилэн дансны ил тод байдал*: Байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, хөрөнгө оруулалтын мэдээлэл, өмч хөрөнгө захиран зарцуулах тогтоолыг Шилэн дансны хууль тогтоомжийн дагуу <http://shilendans.gov.mn> цахим системд сар бүрийн 08-ны өдрийн дотор байршуулан, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангасан. Мөн байгууллагын мэдээллийн самбарт сар бүрийн 5-ны өдрийн дотор төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг шинэчлэн байршуулж олон нийтэд мэдээлж байна.

Мөн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2018 оны эхний хагас жилийн байдлаар 2 удаа аудит хийсэн.

1. 96 хуулийн этгээдийн 2017 оны жилийн эцсийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын дүн: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 86 хувьтай байв. Шилэн дансны нэгдсэн мэдээллийг хуульд заасан хугацаанд 100 хувь оруулсан 70 (77 хувь), 30-50 хувь оруулсан 5 (5 хувь), оруулаагүй 7 (7 хувь) ("Автоимпекс" ХХК, "Эрдэнэс шивээ энерги" ХХК, "Эрдэнэс ассет менежмент" ХХК, "Эрдэнэс Ашид" ХХК, "Эрдэнэс стийл" ХХК, "Гашуун сухайт авто зам" ХХК, "Оюу толгой" ХХК) хуулийн этгээд байв.

2. 94 хуулийн этгээдийн 2018 оны эхний хагас жилийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын дүн: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт дунджаар 88 хувьтай байгаагаас шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээ тайлангаа хуулийн хугацаанд 100 хувь оруулсан хуулийн этгээд 79 (84 хувь), 25-88 хувь оруулсан хуулийн этгээд 6 (6 хувь), мэдээ тайлангаа оруулаагүй хуулийн этгээд 8 (10 хувь) байна. "Автоимпекс" ХХК, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК, "Эрдэнэс шивээ энерги" ХХК, "Эрдэнэс ассет менежмент" ХХК, "Эрдэнэс Ашид" ХХК, "Эрдэнэс стийл" ХХК, "Гашуун сухайт авто зам" ХХК, "Оюу толгой" ХХК шилэн дансны мэдээлэл оруулаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй дээрх хуулийн этгээдэд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгүүлэх, мэдээ мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн оруулах, байгууллагын өөрийн цахим хуудас дахь шилэн дансны цэсээ тогтмол

шинэчлэн, мэдээ мэдээллийг олон нийтэд нээлттэй болгож, хуулийн хэрэгжилтийг хангуулахаар ТӨБЗГ-ын даргын 2018 оны А-1/2135-2141 дугаар албан бичгийг тус тус хүргүүлсэн.

## ХОЁР. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ТАЛААР

### 2.1.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засгийн үзүүлэлт сайжрав.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглалыг сайжруулах, үйлдвэрлэл, санхүүгийн үр өгөөжийг өмнөх оноос дээшлүүлэх, өртөг зардлыг бууруулж, үргүй зардлыг багасган хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажилласны үр дүнд эдийн засгийн чадавх сайжирч, тодорхой үр дүнд хүрэв. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн борлуулалтын орлого 2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 8,629.9 тэрбум төгрөгт хүрч, 932.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай гарч байгаа нь 2017 оны мөн үетэй харьцуулахад орлого 1,563.4 тэрбум төгрөгөөр буюу 22.1 хувиар, цэвэр ашиг 73.1 тэрбум төгрөгөөр буюу 8.5 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь эдийн засгийн үр ашиг санхүүгийн чадавх сайжирсан төдийгүй бизнесийн цар хүрээ нэмэгдсэнийг харуулж байна. Энэхүү тоон үзүүлэлтийн нэгтгэлд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 70 хуулийн этгээд хамрагдсан бөгөөд Сангийн яамны төлөөлөл хэрэгжүүлдэг хуулийн этгээдүүд, “Эрдэнэс Монгол” ХХК болон түүний охин компаниудын эдийн засгийн үзүүлэлтийг оруулж тооцоогүй болно. Борлуулалтын орлого, ашиг, алдагдлын дүнг 4 дүгээр хүснэгтэд харуулав.

4 дүгээр хүснэгт

*Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн борлуулалтын орлого, ашиг, алдагдлын дүн, (сая төгрөгөөр)*

№	Үзүүлэлт	2015 он	2016 он	2017 он	2018 он, ХБГ
1	Борлуулалтын орлого	4,087,875.8	4,566,729.9	7,066,510.6	8,629,903.0
2	Цэвэр ашиг, алдагдал	(-10,485.8)	(-379,912.5)	859,087.6	932,209.0

1.Эрчим хүчний салбар: Төрийн өмчит 26 хуулийн этгээд 2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 13.5 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан. Энэ нь нийгмийн хариуцлага хүлээж улсын төсвөөс татаас авч ажилладаг компаниуд алдагдалтай ажилласантай холбоотой бөгөөд салбарын хэмжээнд ийнхүү алдагдалтай дүн гарахад нөлөөлж байна. Тухайлбал,

- “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК – 5.4 тэрбум төгрөг;
- “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК – 3.3 тэрбум төгрөг;
- “Хөвсгөл дулааны станц” ТӨХК – 106.1 сая төгрөг;
- “Эгийн голын усан цахилгаан станц” ХХК – 3.3 тэрбум төгрөг;
- “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК – 0.9 тэрбум төгрөг;
- “Дулааны цахилгаан станц-2” ТӨХК – 0.8 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

2.Авто замын салбар: Төрийн өмчит 24 хуулийн этгээд 11.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан.


3.Бусад салбар: Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 20 хуулийн этгээд нийт дүнгээр 918.2 тэрбум төгрөгийн ашигтай ажиллав. Эдгээрээс, 2018 оны хүлээгдэж

буй гүйцэтгэлээр “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Эрдэнэс-Тавантолгой” ХК, “Монголросцветмет” ХХК нь 7.2 – 600.0 тэрбум гаруй төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 70 хуулийн этгээдийн ашигтай болон алдагдалтай ажилласан байдлыг 16 дугаар зурагт харуулав.

16 дугаар зураг

2018 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр ашигтай болон алдагдалтай ажилласан хуулийн этгээдийн тоо




## 2.2. Улсын төсөвт төвлөрүүлсэн төрийн өмчийн ногдол ашиг 3.4 дахин нэмэгдэв.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 53 хуулийн этгээд аудитаар баталгаажсан 2017 оны санхүүгийн тайлан тэнцлээр цэвэр ашигтай ажилласан. Эдгээр хуулийн этгээдийн төрийн өмчийн хувьцааны ногдол ашгийн хувь хэмжээг цэвэр ашгийн 10-30 хувиар тооцож, 2018 онд 43.9 тэрбум төгрөгийн ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлэх шийдвэр гарган хэрэгжилтийг хангуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллав.

17 дугаар зураг

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар 27.7 тэрбум төгрөгийн төрийн өмчийн хувьцааны ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлэхээс 43.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн нь төлөвлөснөөс 1.6 дахин, 2017 оны гүйцэтгэлээс 3.4 дахин нэмэгдсэн дүнтэй байна. Төрийн өмчит хуулийн этгээдээс төрийн өмчийн ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлсэн дүнг 17 дугаар зурагт харуулав.



**2.3.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг дахин үнэлж, санхүүгийн тайланд тусгах, үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулав.**

Төрийн болон орон нутгийн өмчийн газар, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах бэлтгэл хангах ажлын хэсгийг холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан ТӨБЗГ-ын даргын 2018 оны А/08 дугаар тушаалаар байгуулан ажиллуулав. “Хөрөнгийн үнэлгээний талаар авах зарим арга хэмжээ, бэлтгэл ажлыг хангах тухай зөвлөмж”-ийг боловсруулан төрийн өмчит 6000 гаруй хуулийн этгээдэд хүргүүлэн хэрэгжилтийг хангуулав. Үнэлгээний ажлын чиглэлээр ГЗБГЗЗГ-тай “Хамтын ажиллагааны санамж бичиг” байгуулж, нийслэлийн Газрын алба, 21 аймгийн ОНӨГ, ГХБХБГ-тай хамтран ажиллав.

18 дугаар зураг



Төрийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, хяналт шалгалт, хөрөнгийн дахин үнэлгээний асуудлаар Нийслэлийн өмчийн харилцааны газар, 21 аймгийн Орон нутгийн өмчийн газар, төрийн өмчит хуулийн этгээдийн холбогдох 221 гаруй ажилтныг хамруулсан 3 удаагийн сургалтыг ТӨБЗГ-т зохион байгуулж, мэдээлэл, зөвлөгөө өгч, мэргэжил, арга зүйгээр хангав (Үйл явдлыг 18 дугаар зургаар харуулав). Хөрөнгийн дахин үнэлгээний бэлтгэл ажлыг хангахад дэмжлэг үзүүлэх, газар дээр нь танилцаж, зөвлөгөө, арга зүйгээр хангах

чиглэлээр нийт 15 аймаг буюу Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл аймагт ажиллав.

ТӨБЗГ-ын 2018 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн талаар авах арга хэмжээний тухай” 273 дугаар тогтоолоор үнэлгээнд хамрагдах үл хөдлөх хөрөнгийг хөрөнгийн үнэлгээний болон нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу дансны нэг ангид бүртгэх арга хэмжээ авч, нийт төрийн өмчит хуулийн этгээдийг хамруулан хэрэгжилтийг хангуулав.

ТӨБЗГ-ын даргын 2018 оны А/65 тоот тушаалаар Монгол Улсаас гадаад улсад суугаа 23 Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшилд байгаа төрийн өмчийн газар, үл хөдлөх хөрөнгийг тоолох, дахин үнэлгээ хийх үүрэг бүхий 10 ажлын хэсгийг байгуулан ажиллуулсан. Ажлын хэсгүүд Дипломат төлөөлөгчийн газрын зохих баримт бичигтэй танилцан, газар өмчлөх эрх болон үл хөдлөх хөрөнгийг тоолох, хэмжилт хийх, үнэлбэл зохих хөрөнгийн тоо хэмжээ, чанар байдлыг тодоройлон нягтлан шалгаж, жагсаалт бэлтгэх, үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээллийг судалгааны маягтын дагуу бэлтгэх, акталж данснаас хасах хөрөнгийн саналыг хянаж, материалын бүрдлийг хангуулж авах зэрэг ажлыг газар дээр нь хийж гүйцэтгэв.

Үнэлгээний аргачлал, заавар, журмыг боловсруулах мэргэжлийн үнэлгээчдийн багийг ажиллуулж, үнэлгээний аргачлал, зааврын төслийг боловсруулан Сангийн яаманд хүргүүлэв. Үнэлгээний аргачлал, зааврын төсөл болон үнэлгээний дүнг нягтлан бодох бүртгэлд тусгаснаар гарах үл нөлөөний асуудлаар Сангийн яам, Мэргэшсэн үнэлгээний институтын төлөөлөл, зарим яам, агентлаг, төрийн өмчит хуулийн этгээдийн санхүү хариуцсан ажилтныг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулсан. Үнэлгээний аргачлалын

төслийг СЯ-ны болон ТӨБЗГ-ын цахим хуудсанд 1 сарын хугацаатай байршуулж, холбогдох байгууллага, иргэдээс санал авсан. Үүний үр дүнд, Сангийн сайдын 2018 оны 207 тоот тушаалаар “Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал” батлагдсан бөгөөд ТӨБЗГ-аас үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулав. Энэ хүрээнд үнэлгээний ажлын гарын авлага, дагалдах CD-г бэлтгэн хэвлүүлж, орон нутаг дахь өмчийн асуудал хариуцсан байгууллагаар дамжуулан нийт төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлсэн. ТӨБЗГ-ын ажилтнууд үнэлгээний аргачлал, зааврыг танилцуулах, арга зүйн семинар, зөвлөгөө, зааварчилга өгөх, орон нутаг дахь үнэлгээний ажилд явцын хяналт хийж, үр дүнг 2018 оны санхүүгийн тайланд тусгуулах асуудалд нягтлан шалгалт хийх чиглэлээр 21 аймаг тус бүрт 2 удаа ажиллалаа (Үйл явдлыг 19 дүгээр зургаар харуулав).

19 дүгээр зураг



Төрийн өмчит 762 хуулийн этгээдийн 443.0 тэрбум төгрөгийн хөрөнгийн бүртгэл, шилжилт хөдөлгөөний асуудлыг шийдвэрлэв.


#### **2.4.Төрийн өмчит 762 хуулийн этгээдийн 443.0 тэрбум төгрөгийн хөрөнгийн бүртгэл, шилжилт хөдөлгөөний асуудлыг шийдвэрлэв.**

2018 онд төрийн өмчит 762 хуулийн этгээдээс ирүүлсэн хөрөнгийн зохицуулалттай холбоотой асуудал бүхий саналыг судлан боловсруулж, ТӨБЗГ-ын 31 удаагийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. Мөн ТӨБЗГ-ын 2017 оны “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам батлах тухай” 86 дугаар тогтоолын 2.1, 2.2-т заасны дагуу Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн даргын албан бичгээр зохих хөрөнгийн зохицуулалтыг шийдвэрлэсэн. ТӨБЗГ-ын 452 тогтоол, холбогдох хэлтсийн даргын албан бичгээр 2018 онд давхардсан тоогоор 762 байгууллагын 55493 нэр төрлийн 443,482.9 сая төгрөгийн хөрөнгийн бүртгэл, шилжилт хөдөлгөөний зохицуулалтын асуудлыг шийдвэрлэн хэрэгжилтийг хангуулсан байна:

- 288 байгууллагын 33968 нэр төрлийн 66,699.6 сая төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан;
- 299 байгууллагын 15121 нэр төрлийн 260,050.5 сая төгрөгийн эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлсэн;
- 67 байгууллагын 253 автомашиныг нээлттэй дуудлага худалдаагаар худалдан борлуулж, 618.3 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн;
- 30 байгууллагад 97 нэр төрлийн нийт 5,875.8 сая төгрөгийн эд хөрөнгийг шинээр худалдаж авах зөвшөөрөл олгосон;
- 78 байгууллагын 6307 нэр төрлийн 110,238.7 сая төгрөгийн эд хөрөнгийг шинээр бүртгэж авах зөвшөөрөл олгосон.

Хөрөнгийн бүртгэл, шилжилт хөдөлгөөний зохицуулалтын дүнг 2017 оны дүнтэй харьцуулж, 20 дугаар зурагт харуулав.

*Хөрөнгийн бүртгэл, шилжилт хөдөлгөөний зохицуулалтын дүн, сая төгрөгөөр*



**2.5. “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2017 оны биелэлтийг дүгнэж, төрийн өмчид бүртгэлээр тавих хяналтыг тогтмолжуулав.**


Төрийн өмчит хуулийн этгээдийн төрийн өмчийн эзэмшилт, ашиглалтад бүртгэлээр тавих хяналтыг тогтмолжуулах, хариуцлагын тогтолцоог сайжруулах зорилгоор “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г жил бүр дүгнэн, дараа оны гэрээг сунган баталгаажуулж хэвшсэн. Төрийн өмчийг эзэмшүүлэх 2017 оны гэрээг дүгнэх, гэрээг сунган баталгаажуулах ажлыг нийслэл, 21 аймгийн төрийн өмчит хуулийн этгээдэд 2018 оны 3 дугаар улиралд хийж гүйцэтгэв.

“Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г дүгнүүлэхэд хамрагдвал зохих төрийн өмчит 1121 хуулийн этгээдээс 801 нь гэрээний биелэлтийг дүгнүүлсэн байна. Уг гэрээг дүгнүүлсэн байдлыг 21 дүгээр зураг, гэрээний биелэлтийн дүнг 22 дугаар зургаар харуулав.

Бүтцийн өөрчлөлтөөр татан буугдсан, орон нутгийн өмчид шилжсэн, нэгтгэгдсэн, хувьчлагдсан, төрийн өмчийн оролцоотой компани, төсөл, сан, хөтөлбөрийн нэгжүүд зэрэг шалтгаанаар төрийн өмчит 277 (25.0%) хуулийн этгээдийн гэрээг дүгнээгүй.


21 дүгээр зураг

*Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г дүгнүүлсэн байдал*



22 дугаар зураг

*“Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2017 оны биелэлтийн дүн*



Нийт 5 багц шалгуур үзүүлэлтийг хангасан байдлын улсын дундаж дүн “сайн” буюу 90.8 хувьтай байна. Төрийн өмчит 96 хуулийн этгээдийн өмчийн ашиглалт, хадгалалт,




хамгаалалтын байдал илүү хариуцлагатай, үлгэр жишээч, шаардлагын түвшинд байна. Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон эрх бүхий бусад байгууллагын тогтоол шийдвэр, журам түүний хэрэгжилтийн байдал “хангалтгүй” байгаа нь гэрээний биелэлтээс дүгнэгдлээ. “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2017 оны биелэлтийн дүнг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцэж, цаашид авах арга хэмжээний талаар тогтоол гаргав.

## 2.6.Төрийн өмчийн түрээсийн орлого 5.4 хувиар нэмэгдэж, 2,169.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэв.

Төрийн өмчийн илүүдэлтэй байр, талбайг түрээслүүлсний орлогоос 30 хувийг улсын төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулан хяналт тавьж ажиллав. 2018 оны жилийн эцсийн дүнгээр төрийн өмчит 74 хуулийн этгээд төрийн өөрийн өмчийн 15,366.88 м.кв байр талбайг нийт 336 түрээсийн гэрээгээр иргэн, хуулийн этгээдэд шинээр түрээслүүлсэн. Харин төрийн өмчит 52 хуулийн этгээд төрийн өөрийн өмчийн 15,733.79 м.кв байр талбайн 426 түрээсийн гэрээг сунгаж ажилласан. Нийт давхардсан тоогоор 126 хуулийн этгээд төрийн өөрийн өмчийн 31,100.67 м.кв байр талбайг 762 түрээсийн гэрээгээр иргэд, хуулийн этгээдэд түрээслүүлж, 2,169.91 сая төгрөгийн түрээсийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэв.


Төрийн өөрийн өмчийн түрээсийн гэрээ болон бусдад байр талбай түрээслүүлж буй төрийн өмчит хуулийн этгээдийн тоог 2017 оны жилийн эцсийн дүнтэй харьцуулан үзэхэд түрээсийн гэрээ 242-оор буюу 46.54 хувиар, түрээслүүлэгч төрийн өмчит хуулийн этгээдийн тоо 28-аар буюу 28.57 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Энэхүү харьцуулсан дүнг 23 дугаар зурагт харуулав.

23 дугаар зураг



Төрийн өөрийн өмчийн түрээслүүлж буй байр талбайн хэмжээ болон түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын мөнгөн дүнг 2017 оны жилийн эцсийн дүнтэй харьцуулахад бусдад түрээслүүлж буй байр, талбайн хэмжээ 47.35 хувиар, улсын төсөвт төвлөрүүлсэн түрээсийн орлого 5.44 хувиар тус тус нэмэгдсэн дүнтэй байна. Харьцуулалтыг 24 дүгээр зурагт харуулав.






**2.7.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бусдаас байр, талбай түрээсэлж ашиглах зардлыг 308.83 сая төгрөгөөр бууруулав.**

Монгол Улсын Засгийн газарт өгсөн Авлигатай тэмцэх газрын 2017 оны “Авлигын эсрдэлээс урьдчилан сэргийлэх тухай” 01/8836 зөвлөмжид өөрийн эзэмшлийн байргүй төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд нь бусдаас байр талбайг өндөр үнээр түрээслэн үйл ажиллагаа явуулж байгаа нь авлига ашиг сонирхлын зөрчил үүсэх боломжтой тул зохих арга хэмжээ авч ажиллах талаар заасан. Энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн ТӨБЗГ-ын 2018 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаар “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын бусдаас түрээсэлдэг байр талбайн түрээсийн төлбөрийн дээд хязгаарыг тогтоох тухай” 01 дүгээр тэмдэглэлээр 1 м.кв талбайн үнийг 30,000.00 (гучин мянган) төгрөгөөс ихгүй байхаар тогтоож, хэрэгжилтийг хангуулан хяналт тавьж ажиллав.


ТӨБЗГ нь 2017 онд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудаас өөрийн байргүй бөгөөд Улаанбаатар хотод түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг 17 компанийн ашиглаж буй байр талбайн хэмжээ, төлбөрийн талаарх судалгааг нэгтгэн ЗГХЭГ болон АТГ-т хүргүүлсэн.

Бусдаас байр, талбай түрээсэлдэг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тоог 2017 онтой харьцуулан төлөөлөл хэрэгжүүлж, удирдлага, менежментийг хариуцдаг байгууллагын харьяаллаар нь 25 дугаар зурагт харуулав.


ТӨБЗГ-ын дээр дурдсан тэмдэглэлийн хэрэгжилтийг хангуулснаар 2018 онд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниуд бусдаас байр талбай түрээсэлж үйл ажиллагаагаа явуулахдаа түрээсийн төлбөрийн дээд хязгаарыг баримтлан ажиллах болсон. Өөрийн байргүй бөгөөд Улаанбаатар хотод түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг компанийн тоо 2018 оны жилийн эцсийн байдлаар 11 болж, өмнөх онтой харьцуулахад 6 нэгжээр буурсан бөгөөд зардал хэмнэгдсэн үр дүнтэй байна.



Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудаас өөрийн байргүй бөгөөд Улаанбаатар хотод түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг компанийн 1 м.кв байр талбайн түрээсийн төлбөрийн дундаж хэмжээг 2017 онтой харьцуулан төлөөлөл хэрэгжүүлдэг байгууллагын харьяаллаар 26 дугаар зурагт харуулав. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын түрээсэлдэг байр талбайн 1 м.кв-д ногдох төлбөр 2017 онд дунджаар 34,969.4 төгрөг байсан бол 2018 онд 25,772.0 төгрөг болж буурсан нь компанийн зардлын хэмнэлтэд тодорхой нөлөөлсөн. Харьцуулалтыг 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар харуулав.



Түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 11 хуулийн этгээд 2018 оны жилийн эцсийн дүнгээр нийт 1,951.0 сая төгрөгийг түрээсийн төлбөрт төлсөн байна. Үүнд, ТӨБЗГ-ын төлөөлөл хэрэгжүүлж байгаа 3 хуулийн этгээд 269.5 сая төгрөг (13.81%), ЗГХЭГ-ын төлөөлөл хэрэгжүүлж байгаа 6 хуулийн этгээд 1,547.74 сая төгрөг (79.33%), СЯ-ны төлөөлөл хэрэгжүүлж буй 2 хуулийн этгээд 133.80 сая төгрөг (6.86%) -ийг түрээсийн төлбөрт зарцуулсан байна. Түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг компанийн түрээсийн төлбөрийн зардлын өмнөх онтой харьцуулсан дүнг төлөөлөл хэрэгжүүлдэг байгууллагын харьяаллаар нь 27 дугаар зурагт үзүүлэв.



Бусдаас байр, талбай түрээсэлж буй төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 11 хуулийн этгээдийн ашиглаж буй байр талбайн түрээсийн төлбөрийн хэмжээ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 308.83 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.


#### **2.8.УИХ-ын 2018 оны 61 дүгээр тогтоолын дагуу төрийн өмчөөс орон нутгийн өмчид 28.1 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг шилжүүлэн хүлээлцэх ажлыг гүйцэтгэв.**

Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын дүнгийн мөрөөр авах арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд Улсын Их Хурлын “Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлсэн. Уг тогтоолын төслийг Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барьж, Улсын Их Хурлын Эдийн засгийн Байнгын хороо, нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх ажлыг гүйцэтгэв. Улсын Их Хурлын 2018 оны 61 дүгээр тогтоолоор төрийн өмчөөс нийслэл, 21 аймгийн өмчид нийт 28.1 тэрбум төгрөг (28,136,741,710.0 төг.)-ийн эд хөрөнгийг шилжүүлэхээр шийдвэрлэсэн.

Орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэн хүлээлцэх ажлыг 21 аймаг, нийслэлд зохион байгуулсан бөгөөд хэрэгжилт 98.0 хувьтай байна. Хөрөнгө хүлээлцсэн ажлын тайлан, дүнг нэгтгэж, Засгийн газарт танилцуулахаар бэлтгэж байна.

#### **2.9.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн 184.8 тэрбум төгрөгийн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авав.**

2018 оны жилийн эцсийн байдлаар төрийн өмчит 22 хуулийн этгээдэд хийсэн хяналт шалгалтын дүнг ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулан тогтоолоор баталгаажуулаад байна. Эдгээр 22 байгууллагын нийт дүнгээр 184.8 тэрбум төгрөгийн зөрчил, дутагдлыг илрүүлэв (28 дугаар зурагт үзүүлэв). Шалгалтаар илэрсэн нийт зөрчлийн 90 хувь буюу 166.3 тэрбум төгрөгийн зөрчил нь худалдан авах ажиллагаатай холбоотой, 10 хувь буюу 18.5 тэрбум төгрөгийн зөрчил нь хууль тогтоомж, холбогдох журмыг зөрчсөн байна. Төрийн өмчит 15 хуулийн этгээдэд хийгдсэн шалгалтын дүнг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэсэн, ТӨБЗГ-ын тогтоолоор дүнг баталгаажуулах ажил хүлээгдэж байна.



Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авч ажиллах талаар ТӨБЗГ-ын тогтоол, хуралдааны тэмдэглэлээр холбогдох хуулийн этгээдийн удирдлагад үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулан хяналт тавьж ажиллав.

**2.10. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд 32.2 тэрбум төгрөгийн төсвийн хэмнэлт бий болгов.**


3.1. ТӨБЗГ-т 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 174.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 133 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгч, нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажлыг гүйцэтгэсэн бөгөөд худалдан авах ажиллагааны явц 91.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

2018 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны үр дүнд 32.2 тэрбум төгрөгийн төсвийн хэмнэлтийг бий болгосон. Худалдан авах ажиллагааны үр дүнг 2017 оны үзүүлэлттэй харьцуулбал, зохион байгуулах төсөл арга хэмжээний тоо 65-аар буюу 96 хувиар, төсөвт өртөг 2.2 дахин буюу 118 хувиар нэмэгдсэн бөгөөд төсвийн хэмнэлт 11.1 дахин буюу 29.3 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Харьцуулсан үзүүлэлтийг 29 дүгээр зургаар харуулав.

**2.11. Монгол Улсад анх удаа ерөнхий гэрээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, төсвийн урсгал зардалд 325.4 сая төгрөгийн хэмнэлт гаргав.**


Засгийн газрын 2017 оны 315 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-д “Зарим ерөнхий нэршлийн эмийг ерөнхий гэрээгээр худалдан авах” ажил тусгагдсан. Энэхүү ерөнхий гэрээний худалдан авах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <https://tender.gov.mn> -ийн дэд систем болох “Цахим дэлгүүр”-ээр дамжуулан Монгол улсад анх удаа зохион байгуулж байна. Зарим ерөнхий нэршлийн 17 нэр төрлийн эмийг ханган нийлүүлэх 10 аж ахуйн нэгжтэй давхардсан тоогоор 40 ерөнхий гэрээ байгуулсан. 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар ерөнхий гэрээний худалдан авах ажиллагааны үр дүнд нийт 361 удаагийн захиалгаар 814144 ширхэг эм худалдан борлуулагдсан бөгөөд улсын төсвийн урсгал зардалд 325.4 сая төгрөгийн хэмнэлт гарсан тооцоотой байна. Ерөнхий гэрээгээр худалдаж буй эмийн бүтээгдэхүүнийг “Цахим дэлгүүр”-т байршуулсан байдлыг 30 дугаар зургаар үзүүлэв.

29 дүгээр зураг



30 дугаар зураг

Ерөнхий гэрээгээр худалдаж буй эмийн бүтээгдэхүүнийг  
“Цахим дэлгүүр”-т байршуулсан байдал



**2.12. Улсын хэмжээнд зохион байгуулах худалдан авах ажиллагааны 88.5 хувийг цахим хэлбэрээр зохион байгуулав.**

2.12.1. ТӨБЗГ нь төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <https://tender.gov.mn> –ийн хэвийн ажиллагааг хариуцан ажиллаж, улсын хэмжээний төрийн худалдан авах ажиллагааны мэдээллийн баазыг үүсгэн, худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулахад мэргэжил, арга зүйгээр ханган ажиллав. Ингэснээр худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, худалдан авах ажиллагаанд оролцогчдод чирэгдэлгүй, хялбар, шуурхай үйлчлэх боломж нөхцлийг бий болгосон.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <https://tender.gov.mn> –ний дэд системээр дамжуулан худалдан авах ажиллагааны мэдээллийг боловсруулан олон нийтэд ил тод мэдээлж байна:

- “Худалдан авах ажиллагааны төлөвлөлт”-ийн систем;
- “Цахим тендер шалгаруулалт”-ын систем;
- “Тендер шалгаруулалтын үр дүн, гэрээ”-ний систем;
- “Цахим дэлгүүр” болон “Цахим каталоги”-ийн систем;
- “Цахим тайлан”-ийн систем;
- “Мэдээлэл солилцоо”-ны систем;
- “Цахим шалгалт”-ын систем.

Худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалтын талаарх улсын хэмжээний 2018 оны тоон үзүүлэлтийг 2017 онтой харьцуулан 31, 32, 33 дугаар зурагт тус тус үзүүлэв.

31 дүгээр зураг




Худалдан авах ажиллагааны цахим системээр 2018 онд зарлагдсан 10817 тендерийн урилгын 9574 нь “Цахим тендер шалгаруулалт”-ын урилга байгаа нь нийт зарласан тендерийн 88.5 хувийг эзэлж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.9 дахин нэмэгдсэн байна. 2018 онд тендер шалгаруулалтын 10202 үр дүн цахим системд нийтлэгдсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 7516-аар буюу 3.8 дахин (280 хувиар), гэрээний мэдээлэл өмнөх оноос 1409-өөр буюу 14 дахин (1381 хувиар) тус тус өссөн.



32 дугаар зураг



33 дугаар зураг



2.12.2.Цахим худалдан авах ажиллагааны системийн сургалтыг худалдан авах ажиллагааны захиалагч байгууллага, тендерт оролцогч аж ахуйн нэгжийн төлөөлөлд нийт 89 удаа зохион байгуулж, 2814 албан хаагч, иргэнийг оролцуулав.

Цахим худалдан авах ажиллагааны системийн сургалт:

- ТӨБЗГ-т 7 хоног бүрийн Мягмар гарагт тогтмол зохион байгуулагдсан 20 удаагийн сургалтад 110 захиалагч байгууллагын 888 албан хаагчийг, Пүрэв гарагт зохион байгуулагдсан 17 удаагийн сургалтад тендерт оролцогч аж ахуйн нэгжийн 207 төлөөллийг хамруулан чадавхийг дээшлүүлж, арга зүйн дэмжлэг, туслалцаагаар хангасан.
- Байгууллагын захиалгат сургалтыг 38 удаа зохион байгуулж, 775 албан хаагчийг чадавхижуулсан.
- “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд АТГ-тай хамтран 14 удаагийн сургалтыг зохион байгуулж, захиалагч болон нийлүүлэгч байгууллагын 944 албан хаагч, иргэнийг оролцуулав.

2.12.3.Нээлттэй гэрээний олон улсын стандартыг Монгол Улсын худалдан авах ажиллагааны тогтолцоонд нэвтрүүлэн [www.opendata.tender.gov.mn](http://www.opendata.tender.gov.mn) цахим системийг хөгжүүлж, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллагууд, судлаачид зэрэг хэрэглэгч талууд төхөөрөмж унших хэлбэрээр татан авах, дүн шинжилгээ хийх, ашиглах боломжийг бүрдүүлсэн.


2.12.4.“Цахим гарын үсгийн тухай” хуулийн дагуу Үндэсний тоон гарын үсгийн хэрэглээг төрийн байгууллагуудаас анхлан хэрэглээнд нэвтрүүлж, тендер шалгаруулалтад цахим гарын үсгийг ашиглаж байна.

**2.13.Хуулийн байгууллагад шийдвэрлэгдсэн хэрэг, маргааны 83.3 хувь нь ТӨБЗГ-ын эрх ашгийг хангаж шийдвэрлэгдэв.**

2018 онд ТӨБЗГ нь шүүх, арбитрын 33 хэрэг, маргаанд нэхэмжлэгч болон хариуцагчаар оролцсон нь өмнөх онтой харьцуулахад 3 буюу 10 хувиар өссөн байна. Шийдвэрлэлтийн байдлыг авч үзвэл, 18 хэрэг, маргаан буюу 55 хувийг эцэслэн шийдвэрлүүлсэн нь өмнөх оны үзүүлэлтээс 12 хувиар буурсан, эцэслэн шийдвэрлэгдсэн хэрэг, маргааны 15-д нь ТӨБЗГ-ын эрх ашгийг ханган шийдвэрлэсэн нь энэ төрлийн шийдвэрлэлт 18 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хуулийн байгууллагад хянагдаж байгаа хэрэг, маргаан, түүний шийдвэрлэлтийн талаарх үзүүлэлтийг 34 дүгээр зурагт харуулав.



34 дүгээр зураг




**4.2. Байгууллагын “Нэг цэгийн үйлчилгээ”-гээр 23312 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлчилгээ үзүүлэв.**


“Нэг цэгийн үйлчилгээ”-гээр 2018 онд 23312 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13878-ээр буюу 2.5 дахин өссөн нь төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт сайжирсантай холбоотой байна. “Нэг цэгийн үйлчилгээ”-ний тоон үзүүлэлтийг 35, 36 дугаар зургаар харуулав.

35 дугаар зураг

“Нэг цэгийн үйлчилгээ”-ээр иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид үйлчилсэн үйлчилгээний төрлийн тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, утсаар өгсөн зөвлөгөө, мэдээлэл 2.3 дахин, биечилж өгсөн зөвлөгөө, мэдээлэл 3.6 дахин, тендертэй холбоотой мэдэгдэл, тодруулга, саналын урилга хүргэсэн үйлчилгээ 2.7 дахин, худалдан авах ажиллагааны цахим системд бүртгэсэн аж ахуйн нэгжийн тоо 0.5 дахин тус тус өссөн байна. Иргэдээс асуусан 603 онлайн асуултад хариулсан нь 0.1 дахин, цахим гарын үсгийн e-token төхөөрөмж олгосон үйлчилгээ 0.5 дахин буурсан байна.



36 дүгээр зураг



## ГУРАВ. ЦААШИД АНХААРЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН САНАЛ, ДҮГНЭЛТ

1. “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д тусгагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг батлуулж, УИХ-д өргөн барих талаар хууль санаачлагчийн хувьд ЗГХЭГ-аас шуурхай арга хэмжээ авч ажиллах.

ТӨБЗГ нь хуулийн төслийг Хууль тогтоомжийн хуульд нийцүүлэн боловсруулж, холбогдох материалын хамт ЗГХЭГ-т хүргүүлсэн. Уг хуулийн төслийг батлуулах зайлшгүй шаардлагатай болон хуулийн төсөлтэй холбоотой нийт 24 албан бичгийг ЗГХЭГ болон дээд шатны байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн болно.

2. Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлсэн. Уг журмын шинэчилсэн найруулгыг батлуулснаар дор дурдсан (3, 4 -т заасан) асуудлыг шийдвэрлэх боломжтой юм. Иймд, журмыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах чиглэлээр ЗГХЭГ-аас шуурхай арга хэмжээ авах.

3. Засгийн газрын шийдвэрээр хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээдээр чиг үүргийн болон чиглэлийн байгууллагыг томилсноор төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг нэгдсэн удирдлагаар хангах, нэгдсэн мэдээлэл гаргах, ТӨБЗГ-ын хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл учирч байна.

4. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигын эсрэг үндэсний чуулганаас гаргасан санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх, авлигын эрсдэлийн түвшинг тогтоох ажлын хүрээнд Засгийн газарт Авлигатай тэмцэх газраас 2017 оны 01/8836 дугаар албан бичгээр хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд чиглэсэн дараах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна:

4.1. Засгийн газрын 2016 оны 49 дүгээр тогтоолоор байгуулагдсан ТӨБЗГ-ын орон тооны бус гишүүдийн бүрэн эрх, чиг үүрэг, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, урамшууллын асуудлыг хууль, эрх зүйн хувьд тодорхой болгох. (Авлигатай тэмцэх газраас Засгийн газарт өгсөн зөвлөмжид ТӨБЗГ-ын орон тооны бус гишүүдийн үйл ажиллагааг энд дурдсан асуудал шийдвэрлэгдэх хүртэл хугацаанд түдгэлзүүлэхээр заасан);

4.2. Төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагыг нээлттэй сонгон шалгаруулалтын үр дүнд томилох зохицуулалт хийх;

4.3. Төрийн өмчит хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг нээлттэй, өрсөлдөөнт шалгаруулалтын аргаар томилдог, үр дүнг тооцдог хариуцлагын тогтолцоог нэвтрүүлэх;

4.4. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний цалин хөлсний хэмжээ, хязгаарлалтыг тогтоох шалгуур, арга зүй, аргачлалыг бий болгох.

5. Дулааны цахилгаан станц, цахилгаан дамжуулах сүлжээ, дулааны шугам сүлжээ зэрэг улсын онц чухал объектын жагсаалтыг Засгийн газраар батлуулж, гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөл үүссэн, аваарь осол гарсан үед гүйцэтгэх удирдлагын асуудлыг хэрхэн шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох. (Тухайлбал, хууль хяналтын байгууллагад шалгагдаж байгаа болон бусад шалтгааны улмаас гүйцэтгэх удирдлага эзгүй байсан тохиолдолд).

6. Төрийн өмчийн бүртгэл мэдээлэлд ашиглаж байгаа “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх цахим систем”-ийг боловсронгуй болгох асуудал “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга

хэмжээний төлөвлөгөө"-нд тусгагдсан. Хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр дутагдалтайгаас шийдвэрлэх боломжгүй байна. Уг системийг боловсронгуй болгоход шаардлагатай хөрөнгийн тооцоог хийж, төсөл боловсруулан 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгуулахаар ЗГХЭГ, СЯ-нд хүргүүлсэн болно.

7. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын эрхлэх асуудалд хамаарах Засгийн газрын аливаа шийдвэрийн төсөлд манай байгууллагаас санал аваагүйгээс Засгийн газрын зарим шийдвэр тодорхой бус, ойлгомжгүй гарч байгаа нь хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байх, хамтран хэрэгжүүлэгчтэй уялдаа холбоо хангагдахгүй байх зэрэг асуудал гардаг.

8. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэх талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн саналыг шуурхай шийдвэрлэж, тодорхой чиглэл, удирдамж өгөх асуудал удаашралтай байдаг.

9. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь төрийн албаны салбар зөвлөлгүй байгууллага учир Төрийн албаны тухай хуулийн дагуу албан хаагчдад зэрэг дэв олгох, төрийн дээд болон бусад шагналаар шагнуулах асуудлыг ЗГХЭГ-т шийдвэрлүүлэхээр ханддаг боловч орхигдох эсхүл удаашрах байдал гардаг. Тиймээс төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах зарим асуудал шийдвэрлэгдэхгүй байх нөхцөл үүсдэг.

10. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, сургах чиглэлээр төсөв хангалтгүй байдаг тул энэ чиглэлээр төсөв, хөрөнгийг нэмэгдүүлэхэд анхаарах.

## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР